

# БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи ба хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл



Зургаа - Александр Есипов

## Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клуб: санаачилгаас үр дүнд

Наталья Шивалдова, Экомактаб, [nshivaldova@mail.ru](mailto:nshivaldova@mail.ru)

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дэмжлэг, идэвхтэн гишүүдийн хичээл чармайлтын үр дүнд тал хээрийн зэрлэг амьтдын хамгаалах клуб нь 2012-2013 байгуулагдсан явдалд талархаж байна. Хэрвээ бид энэхүү санаачилгыг газарзүйд нийцүүлэн харвал илүү их өргөн хүрээнд буюу Халимагийн тал хээрээс Арал тэнгисийн онгон дагшин ландшафтын хэв шинжийг хүртэл олж харж чадна. Эдгээр нутаг дахь хот тосгод нь амьдрал ахуйн уламжлалт хэлбэр, тухайн улс, үндэстний соёл нь дахин давтагдашгүй хэв шинжийг агуулна. Тэд ганцхан хамгийн чухал онцлогоор нэгддэг нь дээрх газрууд нь бүгд бөхөнгийн амьдрах орчинтой хөршлөн оршдог байна.

Олон жил хөршлөн амьдрахдаа хүмүүс өөрсдийн хажуугаар бэлчээрлэж буй бөхөнгийн олон тооны сүрэгт дассан байна. Балар эртний цагаас эхлэн бөхөн нь хоол хүнс, хувцас хунар, шашин болон соёлын шавхагдашгүй эх булаг, байгаль дэлхийн төгс төгөлдөрийн зохицол болсоор иржээ. Хэрвээ бид өнөөдөр хээр талд байршиж буй тосгодод амьдарч буй сургуулийн хүүхдээс бөхөн байгаа эсэх талаар асуувал ихэнх хариулт нь сөрөг үр дүнтэй гарах болно. Хамгийн сайндаа л номны зурагнаас эсвэл хөгшин хүмүүсийн ярианаас тэдгээрийн тосгоны хажуугаар давхилдан өнгөрч байсан хээр талын нүүдэлчид бөхөнгийн тухай хүүхдүүд мэдэж авч байна.

Он жилүүдийн туршид бөхөнгийн эргэн тойронд амьдарч буй хүмүүст “Зөвхөн авах, хэрэглэх” ба, юу ч эргүүлж өгөхгүй байх буруу, нэг хэвийн ойлголт тогтжээ! Байгаль дэлхий энэ хорвоод эсэн мэнд үлдэх, нөхөн сэргэх маш сайн чадвар бүхий бөхөнг бий болгосны ачаар бөхөнгийн сүргүүд саяхныг болтол эсэн мэнд байв. Өнөөдөр бөхөн үнэхээр аюул заналын ирмэг дээр байна. Бөхөнд хэрхэн тусалж чадах вэ? Мөн хэн тэдэнд тулахаар ирэх вэ? Юуны өмнө хүмүүс өөрсдөө бөхөнд хандах зэрлэг бүдүүлэг, хөнөөлт хандлагаа өөрчлөх ёстой бөгөөд гандуу экосистемийн амин чухал хэсэг болсон хээр талд бөхөн байхгүй бол эрчимтэй доройтол нүүрлэх болно гэдгийг сайтар ухаарах хэрэгтэй юм.

### Шавхагдашгүй булгийн багш нар

Өнөөдөр, ер нь хэзээ ч багш нар нийгмийн хамгийн дэвшилтэт хэсэг бөгөөд тэд дэлхий ертөнцийн ёс суртахуун, хүн чанарын тухай бидний хандлагыг хамгийн сайн ухааруулан хамгаалагчид билээ.

Үргэлжлэл 2-р хуудсанд.

Энэхүү хэвлэлийг ивээн тэтгэсэн:

# АГУУЛГА

## Гол мэдээ

*Наталья Шивалдова*

Тал хээрийн ан амьтдыг хамгаалах клуб: Санаачилгаас үр дүнд. **1**

## Шинэ мэдээ

*Кристиана Руттгер*

Астанад зохион байгуулагдсан бөхөн хамгаалах хурал..... **4**

*Юрий Грачев*

Казахстанд 2013 онд хийгдсэн агаарын судалгааны үр дүн ..... **5**

*Наталья Шивалдова, Евгения Самтанова,  
Карлын Самуел болон Занна Аксартова*

## Бөхөн хамгаалах өдөр 2013

Узбекистанд тэмдэглэн өнгөрүүлсэн Бөхөн хамгаалах өдөр..... **5**

Халимагт болсон бөхөнгийн баяр..... **6**

Казахстанд болсон Бөхөнгийн өдөр..... **7**

## Хэвлэлийн мэдээ:

2013 оны 9 сард болсон өөр нэгэн бөхөнгийн үхлийн тохиолдол Хятадад хураагдсан асар их бөхөнгийн эвэр. Байгаль дахь популяцийг тогтворжуулах арга хэмжээний нэг нь бөхөнг зориудын нөхцөлд үржүүлэх.

Узбекистанд автомат зургийн аппарат ашиглаж байна. Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубийнхны харуулсан эко-боловсролын үндэс суурь.

## Өгүүлэл

*Наталья Судец*

Степной БНГ-ын “хилийн будлиан”: хэний газар нутагт бөхөн төллөж байна вэ?..... **12**

*Эмма Марсден ба бусад.*

Узбекистанд 2006-2012 онд бөхөнгийн мониторинг хийсэн мэдээллийн анализ ..... **14**

*Заннур Бакытзанкызы*

Иргыз-Тургай улсын БНГ-т хийгдэж буй бөхөнгийн мониторинг..... **15**

*Леежиах Дорвард ба бусад.*

Пре-Каспийн бөхөнгийн популяцийг статусийг үнэлэхэд хамтын оролцооны мониторингийг ашиглах нь ..... **17**

*Елена Быкова & Александр Есипов*

Узбекистаны Устюртын талын ховор туруутны хууль бус агналтын түвшин ..... **19**

## Бөхөнгийн баатар

*Анатолий Хлуднев, Оросын Холбооны Улс* ..... **20**

## Зарлал

Бөхөнгийн мэдээллийн төв хаалгаа нээлээ!..... **21**

*1-р хуудасны үргэлжлэл:*

Мэдлэгтэй, нухацтай бодон тунгаах чадварыг эзэмшсэн багш нар цаг үргэлж нийгмийн идэвхтэй байх ба тэд нийгэм, хүрээлэн буй орчин үүсэн бий болсон асуудлуудыг шийдвэрлэхэд анхдагчуудын эгнээнд байдаг. Иймээс сургуулийн багш нарын боловсруулан гаргаж ирсэн бөхөн хамгаалах эхний санаачилга нь тал хээрийн бүс нутагт тийм гайхалтай зүйл биш юм. Өмнөх үеийнхний туршлага, эрдэм мэдлэгийг хослуулсан идэвхтэн гишүүдийн эхний бүлэг нь залуу үед өвлүүлэн түгээх ажлыг тал хээрт байх сургуулиудаас эхлэж байна.

“Бөхөн хамгаалах өдөр” хэмээн нэрлэгдсэн өргөн хүрээтэй арга хэмжээ нь тэдгээрийн ур чадвар, эрч хүчийг шалгасан анхны шалгалт байсан ба үүнийг хэрэгжүүлэхэд шууд оролцон, дэмжсэн Бөхөн хамгаалах нийгэмлэг, орон нутгийн засаг захиргаа, улсын байгаль хамгаалах газрын хамт олонд талархал илэрхийлье. Энэхүү арга хэмжээнд Халимаг, Казахстан, Узбекистанд буй тосгодод оршин сууж буй орон нутгийн янз бүрийн нас хүйс, нийгмийн анги давхаргын хүмүүсийг нэг адил хугацаанд хамруулсан (доорхи өгүүллээс хар).

Энэ жилийн тухайд Тал хээрийн зэрлэг амьтдын хамгаалах клуб (ТХЗАХК) үүсэн бий болсон нь бөхөн хамгаалалд орон нутгийн иргэдийн санаачилгыг хүчирхэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл болсон. Халимагийн БНУ-ын Элиста хотод ТХЗАХК нь Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвийн оролцоотойгоор Яшкул тосгоны сургуульд “Амьд өв” нэртэйгээр байгуулагдав. Тус клубийн гишүүд өөрсдийн дүрэм, урт хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлан эмзэг, хөөрхөн бөхөнгийн янзаганы зурагтай логог бий болгожээ.

ТХЗАХК нь Казахстаны Бетпақдала, Уралын бөхөнгийн популяцийн тархац нутагт буй Аккол, Азибай, Нурсай тосгодод мөн зохион байгуулагдсан. Узбекистаны Устюртын бөхөнгийн популяцийн тархац нутагт орших багш нар, орон нутгийн нөхөрлөлийн гишүүд ТХЗАХК-ийн эхлүүлсэн санаачилгыг дэмжин Жаслык тосгоны 54, Каракалпакия тосгоны 56, 26, Нукус тосгоны 37-р сургуулиудад тус тус байгуулжээ.



Өөрсдийн клубийг үүсгэн байгуулахаас өмнө багш нар багуудын хоорондох үйл ажиллагаа, уялдаа холбоог хангахад туслан, экологийн боловсролын семинарыг зохион байгуулсан.

### **ТХЗАХК-ийн зүй тогтол**

ТХЗАХК-ийн үүсгэн байгуулагчдын нэг, Узбекистаны БНУ-ын Каракалпакстаны Нукус тосгоны 37-р сургуулийн багш, идэвхтэн гишүүн Мадина Абдикаримова хэлэхдээ: "Энэ бол гайхалтай, гэвч манай хүүхдүүд бөхөнгийн тухай маш бага мэдэж байна! Саяхныг хүртэл тэдний хот, тосгодтой ойролцоо байсан энэхүү цорын ганц туруутныг мэдэхээсээ илүүтэйгээр тедевиээс, ном зохиолоос Антарктидын пингвин, Африкийн арслангийн тухай мэдээллийг олж авах нь хялбархан болсон өнөө үед бөхөнгийн талаар хэрхэн ойлголт өгөх вэ? Тэдний тоглоомын талбайтай ижил төстэйгээр манай хүүхдүүдийг сонин хачин амьтны аймгийн дүр зураг тойрон хүрээлж байна. Бид хүрээлэн буй орчин, байгаль дэлхийн талаарх өөрсдийн мэдлэгээ алдаж байгаа ийм нөхцөлд би хэзээ ч зайдуу байж, ажиглагчийн байр сууринаас хандаж чадахгүй!

хүрэгчдийн боловсрол мэдлэгийг нэмэгдүүлэх тулгуур болох гэсэн чухал ач холбогдолтой хоёр үйл ажиллагаанд хувааж болно. ТХЗАХК-ийн эн тэргүүнд анхаарах зүйлсийг шийдвэрлэсний дараагаар клубын үйл ажиллагааг тодорхойлон харуулсан. Энэ нь практик хамгааллын үйл ажиллагаанд тэднийг оролцуулснаар, зайлшгүй шаардлагатай судалгааны чадварыг эзэмшүүлсэнээр, харилцаа болон манлайлагчийн үр чадварыг хөгжүүлсэнээр, түүнчлэн тэдний ирээдүйн мэргэжилд шаардагдах үндэс суурийг бий болгосноор залуу үеийнхэнд хүрээлэн буй орчны сонирхох сонирхлыг дэмжихэд ихээхэн ач холбогдолтой юм. Эдгээр үйл ажиллагаа нь хамтдаа бөхөнгийн хууль бус агнуурт залуу хүмүүс оролцох нь ихсэж байгаа өнөө үед залуусыг бөхөнгийн хууль бус агнуурын эсрэг тэмцэхэд оролцуулахад туслах болно. Энэ нь насанд хүрэгсдэд үзүүлэх хүүхдийн нөлөөг нэмэгдүүлэхэд мөн ач холбогдолтой. Бөхөнгийн мах худалдан авах эхчүүдийн саналыг багасгаснаар ёс суртахуунд бөхөнгийн мах идэхийг татгалзсан хүүхдүүдийн талаарх жишээ бидэнд байна.

Зургаа Ирина Гапоненко



**“Амьд ов” ТХЗАХК-ийн гишүүд Оросын Хүнс тэжээлийн судалгааны хүрээлэн, Халимагийн Зэрлэг амьтан хамгаалах төвийн эрдэмтэдтэй хийсэн уулзалтын үеэр.**

Дурсамж, мэдлэгээ алдсанаар бид байгаль дэлхийн үнэ цэнийг мэдрэх мэдрэмжээ алдаж, улмаар тал хээрийн чухал зүйл болох бөхөнг устаж болох аюулыг мэдрэх нь улам бүр багасаж байна. Бид өөрсдийн болон бусад хүмүүсийн, улс үндэстний амьдралын түүхийг агуулсан өөрсдийн гэр, өөрсдийн гудамж, тосгон, бүс нутаг, эх дэлхийдээ өөрсдийнхөө амьдралын мөр, сэтгэл зүрхээрээ хандаж эхлэх хэрэгтэй. Энэ бүхнийг хийхийн тулд экологийн мэдээллээр олон нийтийг хангах орон зайг бий болгох хэрэгтэй. Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клуб нь бөхөн хамгаалалд хувь нэмрээ оруулах, бидний оюун санааны “эх булгийг” эргүүлэн авчрахад ихээхэн боломж олгож байна".

ТХЗАХКлуб нь ердийн сургуулийн экологийн клубээс илүү өргөн хүрээтэй боловч орон нутгийн сургуулиудын идэвхтэн багш нарын үзэл санаанд тулгуурласаар байна. Бүх клубийн гишүүдийг бөхөн болон бусад зүйлийн идэвхтэй хамгаалагчид байж, энэхүү өөрийгөө хамгаалах чадваргүй амьтны хууль бус анг зогсоох хүсэл тэмүүлэл нэгтгэж байна. Клубийнхны үйл ажиллагаа нь хүүхдүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчны боловсрол, насанд

Тал хээрийн зэрлэг амьтдын хамгаалах клуб нь насанд хүрэгсдийн боловсролд тулгуурлан соёлыг түгээх, тэдний ертөнцийг үзэх үзлийг өргөжүүлэх, өнгөрсөн үеийнхний захиасыг биелүүлэхэд чиглэгдэнэ. Үр чадварыг эзэмших боломж, чадварыг нэмэгдүүлэх нь бөхөн хамгаалалд насанд хүрэгсдийн оролцоог нэмэгдүүлнэ. Энэ шалтгаанаас үүдэн цаашид гар урлал, хавсарга урлаг болон байгалийн аялал жуулчлалын төслүүдийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

**Редакторын тэмдэглэл:** Бөхөн хамгаалах нийгэмлэг нь 2012-2013 онд гурван улсад Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубыг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлсэн Ховор зүйлүүдийг хамгаалах Олон улсын сан болон Узбекистанд анхны ТХЗАХК-ийг үүсгэн байгуулахад дэмжлэг үзүүлсэн Disney Canada зэрэг байгууллагад гүнээ талархаж байна.

Зургагч Александр Естинов



**Мадина Абдикаримова болон Нукус тосгоны 37-р сургуулийн “Итгэл” ТХЗАХК-ийн хамт олон Бөхөнгийн өдөрт зориулсан хэвлэлийн бага хуралд өөрсдийн ажлаа танилцуулж байна.**

## Астанад зохион байгуулагдсан бөхөн хамгаалах хурал

Кристиане Руттгер, НҮБХХ/ЗАНЗХ Нарийн бичгийн дарга нарын газар, [CRoettger@cms.int](mailto:CRoettger@cms.int)

Казахстан улсын Астана хотод Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн (ЗАНЗХК) бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичгийн техникийн зөвлөгөөний уулзалт 2013 оны 6 сарын 18-нд болсон. Уг уулзалтын зорилго нь Казахстаны бөхөнд төмөр зам, хилийн торон хашаа зэрэг дэд бүтцийн үзүүлж буй нөлөөллийг хэлэлцэх, эдгээр нөлөөллийг бууруулах боломжит арга замыг тодорхойлох, харилцан ойлголцлын санамж бичгийн олон улсын зохицуулгын механизмыг бий болгох, Бөхөнгийн мэдээллийн төвийн вебсайтын үйл ажиллагааг эхлүүлэх байв.

Оролцогчид Казахстан болон Узбекистаны хоорондох хилийн торон хашааны сөрөг нөлөөллийг бууруулах асуудал (БМ №15-аас хар) болон Казахстанд тавихаар төлөвлөгдсөн дэд бүтцийн төлөвлөгөөг хэлэлцсэн.

БТЗХН, Олон улсын Амьтан, ургамлын аймгийг хамгаалах сан ивээн тэтгэсэн.

Хурлын хоёрдахь хэсэг нь Бөхөнгийн Мэдээллийн төв рүү чиглэсэн асуудлыг хэлэлцсэн бөгөөд уг төвийн цахим хуудсыг бөхөн хамгаалалд оролцож буй судлаачид төдийгүй сонирхож буй олон нийтийн аль алинд зориулан онлайн хэлбэрээр түгээх явдал байв. Бөхөнгийн мэдээллийн төв нь бөхөн хамгаалах орон нутгийн бүлэг, нөхөрлөлийнхөн ашиглахад зориулан судалгааны мэдээлэл, тайлан, зураг, видео зэрэг бөхөнтэй холбоотой бүх мэдээллийг агуулсан мэдээллийн талбар байхаар үүсгэгдсэн. Судлаачдын мэдээллийн хэсэгт бөхөн судлаачдын жагсаалт, бөхөн хамгаалалтай холбоотой төслүүд хамаарагдана. Төр, захиргааны албан хаагч, төрийн бус байгууллага, судлаачид, сонирхож буй хэн боловч энэ хэсэгт бүртгүүлж болох бөгөөд хийгдэж буй бусад үйл ажиллагаа

судлаачдын мэдээллийг олж үзэх болон өөрсдийн хийж буй ажил, туршлага, төслөө танилцуулах боломжтой.

Уг цахим хуудасны үндсэн зорилго нь ЗАНЗХК-ийн бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны мэдээллийг бусдад түгээх, Бөхөнгийн бүтээгдэхүүний худалдаа болон хэрэглээг нийгэд мэдээлэх, харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу хэрэгжиж буй аливаа үйл ажиллагааны арга, туршлага, мэдээллийг хуваалцахад оршино. Бөхөнгийн мэдээллийн төвийг Бөхөн хамгаалах нийгэмлэг болон КБТЗХН, Бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хэсгээс 2 техникийн зохицуулагч оролцон Швейцар улсад байх ЗАНЗХК-ийн нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэг, санхүүжилтээр хэрэгжих болно.



Зургийг Александр Есенов

### Казахстаны БНУ-ын Хүрээлэн буй орчныг хамгаалах яамны дэд сайд Ерлан Ниясанбаев хурлыг нээн үг хэлж байгаа нь.

Ази болон Европийн хоорондох худалдааг ихэсгэх зорилгоор “Шинэ торгоны зам” төслийн хүрээнд нийт 1600 км орчим төмөр замыг 2016 онд гэхэд барихаар төлөвлөжээ. Баруун болон зүүн хэсгийн төмөр замын корридор нь экологийн хувьд хөндөгдөөгүй, хүн амын сууршилгүй зэлүүд нутаг буюу бөхөнгийн амьдах орчныг дайран өнгөрөх болно.

Хуралд оролцогчид доод талын хоёр өргөст урсгыг авах замаар бөхөн ээлтэй хилийн торон хашааны загварыг боловсруулан саналаа өгсөн. Төмөр замаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хамгийн тохиромжтой хувилбар нь бөхөнгийн үндсэн тархац нутгийг дайруулан уг төмөр замыг тавихгүй байх юм. Хэрвээ бөхөнгийн амьдрах орчныг дайруулан тавих төмөр замын бүтээн байгуулалтыг зогсоож чадахгүй бол төмөр замын дагуу хүн амын сууршлыг багасган, хөл хөдөлгөөнийг бууруулах хувилбарыг сонгох ёстой. Бөхөн үзүүлж буй аливаа сөрөг нөлөөллийг зохицуулах механизм нь галт тэрэгнээс “бөхөн хамгаалах татвар” аван санхүүжүүлж болох юм. Эдгээр санал зөвлөмжийг боловсруулах хурлыг ЗАНЗХК-ийн нарийн бичгийн дарга нарын газраас санаачлан, Франкфуртын Амьтан судлалын нийгэмлэг (FZS), Казахстаны

Кирк Олсоны боловсруулсан “Бөхөн зам гарах хувилбар. Казахстан улсын бөхөнд үзүүлж буй төмөр замын корридор болон хилийн торон хашааны хязгаарлах нөлөөг бууруулах санал зөвлөмж, гарын авлага” тайланг доорх холбоосоор татан авч болно.

Англи хэлээр:

[http://www.cms.int/species/eurasian\\_mammals/kirk\\_olson\\_cайгак\\_connectivity\\_sw\\_kazakh\\_e.pdf](http://www.cms.int/species/eurasian_mammals/kirk_olson_cайгак_connectivity_sw_kazakh_e.pdf)

Орос хэлээр:

[http://www.cms.int/species/eurasian\\_mammals/kirk\\_olson\\_cайгак\\_connectivity\\_sw\\_kazakh\\_r.pdf](http://www.cms.int/species/eurasian_mammals/kirk_olson_cайгак_connectivity_sw_kazakh_r.pdf)

Бөхөнгийн мэдээллийн төвийн:

<http://www.cайгакresourcecentre.com/>

# Казахстанд 2013 онд хийгдсэн агаарын судалгааны үр дүн

Юрий Грачев, Амьтан судлалын хүрээлэн, Казахстан, [teriologi@mail.ru](mailto:teriologi@mail.ru)

Казахстанд жил тутам хийгддэг бөхөнгийн агаарын тооллого 2013 оны 4 сарын 4-27-нд хийгдлээ. Казахстаны Амьтан судлалын хүрээлэн, Ой, ангийн зөвлөл, “Охотзоопром” агнуурын менежментийн байгууллага, бүс нутгийн Ой ангийн зөвлөлийн байцаагч нар, КБТЗХН, Зэрлэг амьтан хамгаалах, судлах төвийн мэргэжилтнүүд хамтран оролцов. Урьдчилсан үр дүнгээр 2012 онд 137500 байсан Казахстаны бөхөнгийн популяци 187000 болсон байна.

Бетпақдалагийн популяцид 155200, Устюртын популяцид 5400, Уралын популяцид 26400 орчим толгой бөхөн байгааг тогтоолоо. Бетпақдала болон Уралын популяцийн бөхөнгийн тоо толгой өссөн бол Устюртынх бага зэрэг буурсан байна. 2012 оны тооллоготой харьцуулан үзвэл Бетпақдалагийн популяци 41%-иар, Уралынх 26%-иар тус тус өссөн бол Устюртынх 17%-иар буурчээ. Нийт дүнгээрээ 2012 оныхоос 36%-иар өссөн байна.

Зурвиге КЛОХ МООС РК



## Бөхөн хамгаалах өдөр 2013

*Бөхөн хамгаалах өдөр нь бөхөнгийн тархац нутагт байх бүх улсад тэмдэглэн өнгөрүүлдэг олон улсын экологийн фестивал болжээ. Үүний үндсэн зорилго нь хамгааллын үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээх, энэхүү ховордсон зүйл амьтан руу чиглэсэн хүний хандлагыг өөрчлөх, бөхөнгийн одоогийн байгаа нөхцөл байдалд олон нийтийн анхаарлын хандуулах билээ.*

## Узбекистанд тэмдэглэн өнгөрүүлсэн бөхөн хамгаалах өдөр

Наталья Шивалдова, “Экомактаб” ТББ

Сүүлийн хэдэн жилийн турш Узбекистаны тал хээрт орших тосгодод тэмдэглэн өнгөрүүлж буй Бөхөн хамгаалах өдөр нь орон нутгийн хүүхэд багачуудын дуртай баяр билээ. Энэ жилийн хувьд уг үйл ажиллагааг орон нутгийн бүлэг нөхөрлөлийн идэвхтэн гишүүд, орон нутгийн засаг захиргаатай хамтран зөвхөн сургуулидад зохион байгуулсан. Каракалпастан тосгонд (бөхөнгийн тархац нутагт байх тосгон) уг баярын үйл ажиллагаа энэ жил

Энэ жилийн насанд хүрэгсэд зориулсан экологийн үзүүлэнгийн тэмцээнд сургуулийн хүүхдүүд төдийгүй сувилагчийн сургууль, анагаах ухааны сургууль, хий дамжуулах станцынхан болон тосгоныхон оролцсон. Уламжлалын дагуу уран бүтээл, асуулт хариулт, хөл бөмбөгийн тэмцээн Жаслык тосгонд, харин гар бөмбөгийн тэмцээн Каракалпакия тосгонд зохион байгуулагдсан.

зохион байгуулагдсан бол бүс нутгийн нийслэл Нукуст Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубын гишүүд, багш нарын оролцоотой хийгдсэн. Бөхөн хамгаалах өдрийн хүрээнд шинээр зохион байгуулагдсан үйл ажиллагаа нь орон нутгийн байгаль, хэл, уламжлалыг хамгаалах зорилготой тэмцээн болох “Экологийн буухиа галт тэрэг” байв. Жаслык тосгоны 54-р сургууль, Каракалпакия тосгоны 56 болон 26-р сургууль, мөн Нукус хотын 37-р сургууль энэхүү бөхөн хамгаалах өдрийн баярт анх удаа оролцсон.

Зурвиге Александр Естинов



Каракалпакия тосгоны 26-р сургуулийн бяцхан бөхөнгийн бүжиг.

Орон нутгийн цагдаагийн ажилтнууд, хий дамжуулах станцын ажилчид, орон нутгийн нөхөрлөлийн гишүүд болон тосгоны сургуулийн ахлах ангийнхан “Бөхөн хамгаалагчид” цомын тэмцээнд оролцсон.

Бөхөн хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай хэвлэлийн бага хурал 2013 оны 5 сарын 7-ний өдөр Каракалпакстаны улсын байгаль хамгаалах газрын хурлын танхимд болсон. Уг хуралд Каракалпакстаны тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клубийг энэ хавар үүсгэн байгуулсан шинийг санаачлагч багш нар оролцов. Мөн сэтгүүлчид болон орон нутгийн нөхөрлөлийн сонирхож буй хүмүүс оролцсон. Уг үйл ажиллагааг Узбекстаны Экологийн шижит хөдөлгөөний Каракалпакстаны салбар, Улсын байгаль хамгаалах зөвлөл, Бөхөн хамгаалах нийгэмлэг хамтран зохион байгуулсан.



Зургийг Александр Есманов

**Каракалпакция тосгоны 56-р сургууль, бөхөнгийн талаарх бүтээлийн бяцхан үзэгчид.**

Хэвлэлийн бага хурлын үеэр “Тал хээрийн домог” хүүхэддэйн киног үзүүлсэн (БМ №16-аас хар). Өнгөрсөн жилийн Бөхөн хамгаалах өдрийн хүрээнд хүүхдүүд өөрсдөө уг киног хийсэн болохыг дурдах хэрэгтэй. Хэлэлцүүлгийн дараа оролцогчид бөхөн хамгаалалд үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хэрэгтэй бөгөөд бөхөнг орон нутгийн бүлэг нөхөрлөл болон төр засаг хамтран ажиллаж гэмээнэ хамгаалж чадахыг хүлээн зөвшөөрсөн.



Зургийг Александр Есманов

**Экологийн буухиа галт тэрэг тэмцээнд оролцож буй Каракалпакция тосгоны 56-р сургуулийн “Уламжлал” тоглолтын хэсгээс.**

## Халимагт болсон Бөхөнгийн баяр

Евгений А. Самтанова, "Амьд өв" Тал хээрийн зэрлэг амьтан хамгаалах клуб

Энэ жилийн Бөхөнгийн баяр Яшкул тосгоны сургуульд 2013 оны 4 сарын 17-нд болсон. Халимагийн 7 сургуулиас, мөн хөрш зэргэлдээ орших Ростов мужийн Орловский тосгоны сургуулиас сурагчид ирж оролцсон. Баярын үйл ажиллагааг Халимагийн уламжлалт зан үйл болох “Энэ бол бөхөнгийн тухай бодох цаг”-аар нээсэн. Үүнд Яшкул тосгоны Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубийн тэргүүн (ТХЗАХК) орон нутгийн бүлэг нөхөрлөлийн гишүүдийг хүрээлэн буй орчны асуудлуудын хажуу талд зогсолгүйгээр эх дэлхийнхээ “төвд нь” идэвхтэй зогсдог оршин суугч байхад уриалсан. Тэд бөхөнгийн бууралтын шалтгааныг тодорхойлсон аялгуут шүлэг, Будда бурханы тухай орон нутгийн домог хэлэлцэн, бөхөн агнахгүй байхыг анчдад захидаг Цагаан хөгшин хүн буюу аавын талаарх домгийг ярьж байв. 5-6 ангийн сурагчдын тоглосон концерт гартаа “Халимагийн тал хээрийн амин чухал зүйл бөхөн гэдэгт бидэнд итгэ. Хэрвээ бид үүнийг хадгалж чадахгүй алдвал бид өвөг дээдсийнхээ журмыг зөрчих болно” гэсэн уриаг барин төгсгөсөн.

Бөхөнгийн өдөр нь театрт ТХЗАХК-ийнхны концертоор үргэлжилсэн бөгөөд өөр өөр сургуулиас ирсэн хүүхдүүд бөхөн болон түүний эргэн тойрон

амьдарч байгаа хүмүүс зэрэг бусад зүйлсийг харуулсан тэмцээнд оролцсон. Бүх өмсгөл болон үе шатыг хүүхдүүд өөрсдөө хийсэн. Мөн тэнд “Тал хээрийн гөрөөс” тэмцээнд оролцсон хүүхдүүдийн хамгийн шилдэг бүтээлийг дэлгэн харуулсан үзэсгэлэн амжилттай зохион байгуулагдсан. Үзэсгэлэнд ирүүлсэн 136 бүтээлийг зураг, гар урлал, зохион бичлэг, шүлэг гэсэн 4 төрөлд хуваасан.



Зургийг Евгения А. Самтанова

**Амьд өв тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубийн тоглолт.**

ТХЗАХК-ийн тэргүүн “Бөхөнг хадгалж, хамгаалахад бидэнд зөвшөөрөөч” нэртэй бүжгийн тэмцээнийг хөтлөн оролцож буй хүүхдүүдийг 4 багт хуваан завсарлагын хугацаанд бөхөн хамгааллын тухай асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулсан. Уг арга хэмжээг баг тус бүрийн төлөөлөл хонхны дуугаар хаасан. Хонх дуугаргах нь бөхөн хамгаалах шаардлага өсөн нэмэгдэж байгаа бөгөөд маргааш болбол хоцорч магадгүйг билэгдсэн: Бид зөвхөн бөхөнг хамгаалж чадахыг хайхралгүйгээр бусад хүмүүс бөхөнг хамгаалах нь тэдний асуудал болохыг ойлгуулахын тулд хонх чангаас чанга дуугарах болно.



Зургаа: Евелена А. Савицкая

Ердниевын сургуулийн багийн концерт.

## Казахстанд болсон бөхөнгийн өдөр

Карлын Самуел, Занна Аксартова

Энэ жил КБТЗХН гуравдахь удаагийн Бөхөн хамгаалах өдрийг Казахстанд зохион байгуулав. 2011 онд хийгдсэн анхны Бөхөн хамгаалах өдөрт 5 тосгоны 5 сургууль оролцож байв. Анхны баярт 350 гаруй хүүхэд оролцон шүлэг, богино түүхийг харуулсан тоглолт болон асуулт хариулт, уран зургийн тэмцээн зохион байгуулагдсан. Энэ жил 500 гаруй хүүхэд, тэдний гэр бүл, сайн дурынхан уг өдрийг тэмдэглэхээр хамтдаа хүрэлцэн иржээ.

Бөхөн хамгаалах өдрийн гол арга хэмжээ нь орон нутгийн нөхөрлөлийн ахлагчид, тосгоны хөгшдийг уг баярын арга хэмжээнд оролцуулахыг урьтал болгосно бөгөөд тэд уг арга хэмжээний идэвхтэй хэсэг байж, үг хэлэх, үзэсгэлэнг харах, шагнал өгөхөд гол үүрэг гүйцэтгэсэн.

Уг арга хэмжээ концерт, шүлгийн уралдаан, бүжгээр эхлэн, албан хаагчид, хүүхдүүдийн гэр бүлийнхэн, найзууд



Зургаа: КБТЗХН

Хүүхдүүд бөхөнтэй, хээр талд амьдрах бусад амьтдын талаар суралцахдаа баяртай байдаг.



Зургаа: КБТЗХН

Өөрийн ой санамжаар бөхөнг зурж чадах уу?

хүүхдүүдийн өмнөх долоо хоногт бэлдсэн бөхөнгийн үзэсгэлэн, шинжлэх ухааны төслүүдийг үзсэн.

Энэ жилийн Бөхөнгийн өдөрт бүх насны хүүхдүүд оролсоноор онцлог бөгөөд тэдэнд тохирсон хөтөлбөр, мэдээллийг өгөх зорилгоор насны ангиллаар хуваасан.

Бага насны хүүхдүүд, тэдний гэр бүлийнхэнд бөхөнгийн тухай шинэ хүүхэлдэйн киног үзүүлэн, үүний дараа тэд юу зурсанаа зураг зурж харуулсан. Арай насаар ахмад хүүхдүүд нь “Бөхөнгийн марафон” хэмээх бөхөнгийн биологи, экологийн тухай мэдлэгийг шалгах, бөхөн зурах, асуултанд хариулах зэрэг хэд хэдэн үе шаттай тэмцээнд багаар оролцсон. Баярын төгсгөлд нийтээрээ бөхөн болон хулгайн анчдын тухай саад бэрхшээл, тайралттай тулгарах үед тэд хэрхэн зугтаадагыг харуулсан хөгжөөнтэй тоглоом тоглон дуусгасан.

Бөхөнгийн өдрөөр ахлах ангийнхан анх удаа “21-р зууны эко-лидер”-ийн төлөө уралдсан. Энэ нь тэдний хамгааллын тухай мэдлэг, хүрээлэн буй орчны төлөө хүлээсэн үүрэг, тал хээрийн гайхамшигт биологийн олон янз байдлыг ирээдүйд хамгаалагчид болох асар их хүсэл тэмүүллийг харуулсан өрсөлдөгч багуудын санаа, хамтын ажиллагааг харуулсан тэмцээн болсон.

Уг баярын үнэхээрийн эерэг үр дүн нь өөрсдийн улсад бөхөнг хамгаалахад хэрхэн тусалж чадах, хэр зэрэг чухал үүрэгтэй болохоо хүүхдүүд ойлгосноо харуулсан явдал билээ.



Тал хээрийн “аваргуудын ” ирээдүйн халаа.

## Хэвлэлийн мэдээ

### 2013 онд болсон өөр нэгэн бөхөнгийн үхлийн тохиолдол

Бетпақдалагийн популяцид бөхөнгийн тоо толгой их хэмжээгээр хорогдсон явдал 2013 оны 9 сарын 7-нд Казахстаны Акмола, Караганда бүсэд тэмдэглэгдсэн. Тэнгиз нуурын өмнөд, баруун болон хойд булангаас түүнчлэн задгай хээрт үхсэн бөхөнгүүд тохиолдож байв.

Бөхөнгийн үхлийн шалтгааныг тогтоохоор Казахстаны БНУ-ын Хүрээлэн буй орчныг хамгаалах яам, ХАА-н яам, Дотоод хэргийн яам, Боловсрол, Шинжлэх ухааны яам болон бусад байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийнхэн 9 сарын 8-наас 12-ны хооронд бүс нутгийн засаг захиргааны төлөөлөл, Биоаюулгүй байдлын хүрээлэн, Караганда мужийн мал эмнэлгийн албатай хамтран бөхөн үхсэн газар луу барим нотолгоог шалгахаар явав.

Уг судалгаагаар нийт үхсэн амьтны тоог (газраар болон агаараар) өмнө мэдээлэгдэж байсан 3000 толгойгоос <http://www.eco.gov.kz/new2012/2013/09/3126-192/> харьцангуй цөөн буюу 791 гэж тогтоосон <http://www.eco.gov.kz/new2012/2013/09/3127-81/>. Астанад 2013 оны 9 сарын 10-нд болсон хэвлэлийн бага хурлаар Ой, ангийн зөвлөлийн дарга Бахытбек Дуйсекеев үхсэн амьтдаас цуглуулсан дээжинд хийсэн шинжилгээний урьдчилсан дүнгээр пастереллэз илэрсэн болохыг тэмдэглэсэн.

Энэ нь Казахстанд болсон бөхөн үхсэн анхны тохиолдол биш бөгөөд 2010, 2011, 2012 онуудад нийтдээ 13000 гаруй амьтан Урал болон Бетпақдалагийн популяцид үхсэн байна. Хамгийн сүүлийн үхлийн шалтгаан болох пастереллэз болох тухай албаны эх сурвалжийн мэдээг харгалзан үзвэл энэ таамаглал нь өмнөх үхлүүдтэй зөрчилдсөөр байна. (Бөхөнгийн мэдээ 11, 13, 14, 15-аас хар).

Томоохон хэмжээтэй, олон тоогоор пастереллэзоор халдварлан үхсэн тохиолдол Казахстанд 1981, 1984, 1988 онд тохиолдож байжээ (БМ-11-ээс хар).

### Хятадад хураагдсан их хэмжээний бөхөнгийн эвэр

Баруун хойд Хятадын хилийн албаныхан 2013 оны 9 сарын 5-нд 4470 эвэр хийсэн 35 хайрцагийг илрүүлсэн бөгөөд хил давуулагчид хууль бусаар нэвтрүүлэхийг завджээ. Уг хайрцагнуудыг ачааны автомашины арын суудал доогуур нуусан байсан бөгөөд нийт өртөг нь 22 сая доллараар үнэлэгдэж байна.



Хятадад 9 сарын 5-нд хураагдсан бөхөнгийн эвэр.

Хилийн боомтоос 40 км-т орших хилийн цагдаагийнхан ачааны автомашины жолоочыг Хятадад хүлээж байсан 3 хамсаатныг баривчилсан. Энэхүү мэдээнд дурдсан үнэ нь эврийн зах зээлийн үнэлгээ биш бөгөөд харин Хятадын



айлгах зорилгоор зах зээлийн бодит үнээс илүү их өндөр байдаг Хятадын шүүхийнхний ашигладаг үнэлгээний системд суурилсан. Хураагдсан хилийн шалган нэвтрүүлэх боомт нь Хятад, Киргизстаны хил дээр байдаг нь уг эврүүд Казахстанас гаралтай болохыг баталж байна.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Лауриэ Блэйкийн видео мэдээллээс авна уу: <http://news.uk.msn.com/video-clips?videoid=773431b9-e1bf-4d98-9440-0f6031daa94c#tscptmf>.

Энэ оны эхээр (2013 оны 5 сарын 12) 719 бөхөнгийн эвэр Хятадын Шинжаан мужийн Алашаны боомт дээр хураагдсан билээ. Гурван хятад иргэн, нэг казах иргэн хэрэгт холбогдсон. Үрэмчи хотын гаалийн ажилтны мэдээлсэнээр Үрэмчийн хилээр өнгөрч буй Алматы ба Үрэмчийн олон улсын галт тэрэг нь бөхөнгийн эврийг хууль бусаар хил давуулах хамгийн таатай зам болдог талаар мэдээлсэн. [http://www.xinjiangnet.com.cn/xj/corps/201306/20130623\\_3329891.shtml](http://www.xinjiangnet.com.cn/xj/corps/201306/20130623_3329891.shtml)



Зургааг Xinjiangnet.com.cn



Үрэмчид хураагдсан бөхөнгийн эврийг гаалийн ажилтнууд шалгаж байгаа нь, 2013 оны 5 сарын 12.

## Байгаль дахь популяцийг тогтворжуулах арга хэмжээний нэг нь бөхөнг зориудын нөхцөлд үржүүлэх юм

Ростов мужийн Орловский тосгонд 2013 оны 5 сарын 28-30-ны хооронд “Бөхөнг (Saiga tatarica L.) зориудын нөхцөлд үржүүлэх, хамгаалах” сэдэвт олон улсын хурал болсон. Энэ нь уг асуудалд чиглэсэн анхны хурал байсан бөгөөд үүнийг 2003 оноос хойш бөхөнг зориудын нөхцөлд өсгөн үржүүлж буй “Хээрийн бүлгэмдлийн ан амьтад” ТББ-аас санаачлан хийсэн. Уг хурлыг ОХУ-ын Байгалийн нөөцийн яам, Ростов мужийн захиргаа, Ростов мужийн ИТХурлын танхим, ЮНЕСКО, Оросын Шинжлэх ухааны академийн Уралын салбарын Хээрийн судалгааны хүрээлэн, Өмнөд улсын их сургууль, Оросын Шинжлэх ухааны академийн өмнөд хэсгийг хариуцсан шинжлэх ухааны төв, Ростовийн Биосферийн нөөц газар болон бусад байгууллагууд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн.



Зургааг Надежда Архилова

### Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвийн Яшкул дахь үржүүлгийн төвд буй бөхөнгүүд.

ОХУ дахь бөхөнгийн тархац нь Халимагийн БНУ-ын Астрахан мужид байх агаад Ростов мужийн зүүн хэсгээр ховор тохиолдоно. Хамгийн сүүлийн албан ёсны мэдээгээр бүс нутгийн бөхөнгийн популяцийн хэмжээ ноцтой багасан, 5000 орчим толгойд хүрсэн бөгөөд сүрэгт эзлэх эрэгчний тоо бага байна.

Уг хуралд нийт 75 төлөөлөгч оролцсоноос ОХУ-д байх бөхөн үржүүлгийн хоёр төвийн төлөөлөл буюу Ховор амьтдын төлөөх хээрийн бүлгэмдлийн төв, Халимагийн БНУ-ын Яшкул дахь үржүүлгийн төв, Ховор амьтдыг хамгаалах төвийн албан хаагчид мөн оролцсон. Хуралд оролцогсод тогтвортой популяцийг бий болгохын тулд тэдгээрийг нөхөн сэргээх, бөхөнг зориудын нөхцөлд үржүүлэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж байв. Эдгээр аргууд нь ховор зүйлүүдийг нөхөн сэргээх хамгааллын ажилд олон улсад түгээмэл хэрэглэгддэг. Нийтээрээ мэдэх жишээнүүдэд бизон, Пере Давидын буга, тахь адуу зэрэг нь зориудын нөхцөлд үржүүлж байсны хүчинд эргэн сэргээж чадсан билээ. Сүүлийн жилүүдэд Монгол болон Хятадад энэ өзүйлийн байгалийн популяцийг бий болгох талаар ихээхэн дэвшилтэй ажил хийгдэж байгаа билээ.

Уг хурлаас доорх шийдвэрүүд гарсан:

1. Байгаль дахь бөхөнгийн популяцийн эмзэг нөхцөл байдлыг хэлэлцэн холбогдох засаг захиргаадад бөхөнг сэргээн нутагшуулах, зориудын нөхцөлд үржүүлэх талаар анхаарал тавин, хамгааллын ажлыг зохион байгуулах талаар зөвлөмж хүргүүлсэн.

2. ОХУ-ын Байгалийн нөөцийн яам нь бөхөнг зориудын нөхцөлд үржүүлэх талаарх Бөхөн хамгаалах улсын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ёстой.

3. Байгалийн нөөц, Экологийн яам ОХУ-ын улаан номонд бөхөнг оруулах хэрэгтэй.

4. Байгаль дахь бөхөнгийн популяцийн статусыг дээшлүүлэхийн тулд Улсын Дум хууль бус агнуурын шийтгэлийг улам илүү чангатгахын тулд ОХУ-ын Эрүүгийн хуульд нэмэлт оруулах хэрэгтэй. Хууль бус агнуур болон саарал чонын популяцийг хянах хяналт сул байгаа нь зөвхөн зэрлэг бөхөнд төдийгүй сэргээн нутагшуулж буй бөхөнд сөрөг нөлөөтэй. Баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцид илүү их эмзэг байгаа учраас дээрх ажил нь хамгийн чухал шаардлагатай юм.

5. Бөхөн үржүүлгийн төвд одоо хийгдэж байгаа туршлагыг судлах нь зориудын нөхцөлд үржүүлж буй популяцийг нэмэгдүүлэх, тэдгээрийг судалгаа шинжилгээний журмаар судлах, сэргээн нутагшуулах, бусад зорилгоор ашиглахын тулд ферм, амьтны хүрээлэн, үржүүлгийн төв рүү зөөвөрлөх зорилгоор нэмж үржүүлгийн газар байгуулахад ихээхэн ач холбогдолтой юм. Зөвлөмж болгож буй энэ ажлыг бүс нутгийн болон орон нутгийн захиргааны байгууллага, бизнесийн, санхүүжүүлэх газрууд дэмжих хэрэгтэй.

6. Халимагийн БНУ-ын эерэг туршлага дээр тулгуурлан зөвлөмж болгоход бүс нутгийн засаг захиргаанаас бөхөнгийн түүхий эд, дайвар бүтээгдэхүүний худалдааг хориглох ёстой.

7. Оросын Шинжлэх ухааны академийн Уралын салбарын санаачилсан жил бүрийн 5 сарын 31 нд “Тал хээрийн өдөр” экологийн наадам, Оросын газарзүйн нийгэмлэгтэй хамтран 2014 оныг “Тал хээрийн жил” болгон зарлах явдлыг хуралд оролцогчид дэмжиж байна.

*Илүү дэлгэрэнгүйг доорх холбоосоор орж харна уу:*

<http://civil-society.donland.ru/Blog/ViewPost.aspx?pageid=97328&ItemID=93121&mid=90327>

Зургийг Евгений Поповский



Зургийг Ан амьтаны төлөөх зургийн нийгэмлэг

Хуралд оролцогсод.

## Узбекистанд автомат зургийн аппарат ашиглаж байна

Узбекистаны БНУ-ын Байгаль хамгаалах улсын хорооны дэргэдэх Биохяналтын улсын хороонд 7 сарын 19 нд “Биологийн олон янз байдлын судалгаанд автомат камерын хэрэглээ: Устюртын тал нутгийг судлах шалтгаан” нэртэй семинар зохион байгууллаа.

Уг үйл ажиллагааг Биохяналтын улсын хороо, Бөхөн хамгаалах нийгэмлэг, Майкл Зуковын сан, Жижиг мий хамгаалах сан (SCCA) хамтран зохион байгуулсан. Зэрлэг ан амьтан хамгаалах сүлжээний дэмжлэгтэйгээр Бөхөн хамгаалах нийгэмлэг, Жижиг мий хамгаалах нийгэмлэгийн солилцооны аялалын хэсэг болгон Өмнөд Устюртад хамтарсан экспедици зохион байгуулсан байна.

Зургийг Александр Есипов



Жим Сандерсон болон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн баг.

Уг аялалын үндсэн зорилго нь цаашдын судалгааг дэмжин автомат гэрэл зургийн аппарат ашиглах болон Узбекистан дахь бөхөн болон бусад ховор амьтдыг хамгаалах практик сургалт хийх байв. Энэ арга нь амьтны зан төрх, популяцийн хүйс, насны бүтэц, хүний гараар бүтээгдсэн дэд бүтцийн зэрлэг амьтдад үзүүлэх нөлөө зэрэг орчин үеийн асуудлыг судлахад маш тохиромжтой билээ.

Хэдийгээр автомат гэрэл зургийн аппаратыг харьцангуй сүүлийн үеэс ашиглагдаж эхэлж байгаа боловч амьтан судлаачид маш сайн мэднэ. Энэ нь ашиглахад хялбархан, эдийн засгийн болон үр дүн сайтай эд юм.

Өмнө нь амьтан судлаачид амьтдын амьдралыг ажиглан хэдэн долоо хоногоор сууж, тэдгээрийг үргээж цочоохоос эмээн суудаг байсан бол одоо энэ бүхэн маш энгийн болсон бөгөөд амьтны гүйдэл, зам дээр автомат камераа тохируулан тавьж, шаардлагатай үедээ мэдээллээ авах болно. Камерны мэдрэгч нь маш мэдрэг учраас автомат аппаратыг хөдөлгөөнгүй биеттэй ойрхон бэхлэх шаардлагатай, үгүй бол салхины хөдөлгөөнөөр камер идэвхжих болно. Тиймээс камерыг тохируулан тавьж буй судлаач хүн зөвхөн техникийн мэдлэгтэй байгаад зогсохгүй зэрлэг амьтдын амьдрах орчны мэдлэгтэй байх шаардлагатай ба мөн топографийн онцлогийг харгалзан камерыг зөв чиглүүлэх, нууцлах, бусад хүчин зүйлийг мэдрэх чадвартай байх хэрэгтэй.



Зургийг Александр Есенов

**Александр Григорианц Ташкентийн “автомат камер хэрэглээ” сургалтыг нээж байна.**

Түүний яриа маш сонирхолтой байсан. Узбекистанд өнгөрсөн онд анхны автомат камерыг ашигласан бөгөөд тэдгээрийн урьчилсан үр дүнгүүд аль хэдийн гарсан. Валентин Солдатов “Узбекистаны Джейран Эко төвд автомат камерыг анх удаа амжилттай туршлаа” сэдэвт илтгэлдээ өөрийн туршлагаа хуваалцлаа. Туран ТББ-ын гишүүн Мария Грицына Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний солилцооны хөтөлбөрийн хэсэг болсон Өмнөд Устюртад хийсэн аялалын үр дүнг танилцуулав. Наталия Мармазинская ба Елена Быкова нарын бэлдсэн илтгэлд Майкл Зуковын сан болон ДДБОХС/НУБ-аас санхүүжүүлэн Устюртын тал нутагт хийгдэж байгаа ажлуудыг танилцуулсан. Автомат камерын хэрэглээ нь ихээхэн өндөр үр дүнтэй байдгийг судлаачид санал нэгтгэйгээр зөвшөөрцгөөв. Тэд бол Узбекистаны амьтны аймгийг илүү сайн ойлгоход туслах найдвартай гэрэл зураг болон видеог олж авах судлаачид байх болно.

Илүү дэлгэрэнгүйг доорх холбоосоор орж харна уу  
<http://econews.uz/index.php/item/2080-в-узбекистане-применяют-новые-методы-наблюдений-за-животными.html>.

## Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубийнхны туршсан эко боловсролын үндэс суурь

Нукуст 2013 оны 3 сарын 25-26-нд “Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах клубийнхны туршсан эко-боловсролын үндэс суурь” сэдэвт багш нарт зориулсан сургалт боллоо. Энэхүү сургалтыг Бөхөн хамгаалах нийгэмлэг Экомактаб төрийн бус байгууллага, Байгаль хамгаалах үндэсний хорооны



Зургийг Александр Есенов

**Сургалтанд оролцогчид.**



Зургийг Александр Есенов

**Автомат гэрэл зургийн аппаратыг тохируулж байгаа нь.**

Бүх камерууд маш энгийн зарчмаар ажиллана. Тэдгээр нь хөдөлгөөн илрүүлэх мэдрэгч, зургийн аппарат (видео бичлэг хийх үйлдэлтэй) болон харанхуй нөхцөлд зураг авах боломжийг олгодог мэдрэгч гэрэл гэсэн 3 үндсэн бүрдэл хэсэгтэй. Үүн дээр нэмэгдэн батерей буюу зай шаардлагатай. Өнөөгийн байдлаар автомат камерууд нь 6 сард тутамд судлаачил шалгаж чадах зарим алслагдсан нутагт удаан хугацааны турш “автоном” горимд ажиллаж чадна.



Зургийг Александр Есенов

**Жим Сандерсон Ташкентын хурал дээр автомат камерны талаарх өөрийн мэдлэгээ хуваалцаж байна.**

Жижиг мий хамгаалах сангийн захирал доктор Жим Сандерсон дэлхий дээрх уг аргачлалыг олон жилийн турш ашигласан өөрийн туршлага дээрээ тулгуурлан автомат камер, мэдээллийг хадгалах, анализ хийх талаар семинар хийсэн.

орон нутгийн салбар, Нийтийн боловсролын яам хамтран зохион байгуулсан. Уг сургалтын зорилго нь өөрсдийн сурагчдын дунд экологийн соёлыг бий болгон хөгжүүлэхийн тулд боловсрол олгох аргачлалыг сайжруулах, багш нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд оршиж байв.

Зургаа Александр Есинов



Залуу багш нарын дунд хийгдсэн боловсролын тоглоомыг харуулж байгаа нь.

Мөн өөр сургуулиас ирсэн багш нарыг уулзуулах, өөрсдийн санаа, туршлага солилцох, экологийн боловсролыг сонирхож байгаа бусад багш нартай холбогдоход чухал түлхэц болсон.

Сургалтын явцад ТХЗАХК-ийнхэн сурагчдад бүтээлч-шинжлэх ухаанч чадварыг бий болгох, хүрээлэн буй орчны хамгаалалд болон амьтны болон ургамлын аймгийн дахин давтагдашгүй зүйлүүд, бүс нутгийн ховор зүйлүүдийн хамгаалах үйл хэрэгт хүүхдийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх зэрэг эко-боловсролд түлхэц өгөх нэмэлт сургалтын төлөвлөгөөг тайлбарлав. Уулзалтын үеэр багш нар хэрхэн Бөхөнгийн өдөрт бэлдэх талаар зөвлөлдөн, санаа бодлоо хуваалцаж, эдгээр үйл ажиллагааны төлөвлөлт, шаардлагатай зүйлсийн талаар хэлэлцлээ. Устюрт, (# 26, 54 болон 56 сургуулийн) болон Нукусаас (# 4, 34, 27, 1, 32, 37 ба 29-р сургуулийн) нийт 16 багш, түүнчлэн Байгаль хамгаалах орон нутгийн хорооны гишүүд, Эко-движение улс төрийн намынхан оролцсон байна.

Дэлгэрэнгүйг доорх хаягаар авна уу:

<http://www.nuz.uz/rubrik/detail/2450/7573/> ба  
<http://www.econews.uz/index.php/item/1948-основы-эко-образования-на-примере-степных-клубов.html>

## ӨГҮҮЛЛҮҮД

### Степной БНГ-ын “хилийн будлиан” : Хэний газар нутагт бөхөн төллөж байна вэ?

Наталья Судец

Чөлөөт сэтгүүлч, [brigantine@yandex.ru](mailto:brigantine@yandex.ru)

2013 оны 8 сарын 2-ний өдөр Халимагийн БНУ-аас “бөхөн төллөдөг нутаг” болох Астрахань мужийн Степной БНГ-ыг чиглэн хоёр гэр, байшин барих дүнд ачсан олон тооны машин очсон. Үүнийг сөхөн үзвэл тэдгээр айлчид нь адуу, тэмээ, ямаагаа тэнд маллахаар очсон монгол айл өрхүүд байсан.

БНГ-ын энэ хэсэг нь бөхөн сэргээн нутагшуулж байгаа хэсэг юм. Эдгээр урилгагүй зочид зэрлэг ан амьтдыг ус уух зорилгоор 10 жилийн өмнө Степной БНГ-ын ажилчдын сэргээн босгосон гүний устай булгийн хажууд гэрээ босгосон байв. Эдгээр монголчууд оросоор ярьж чадахгүй байсан ба тэдний үйлдэл ТХГН-ийн дүмийг зөрчиж байгаа талаар юу ч ойлгохгүй байв.

Тэд мөн ОХУ-ын бүрэлдэхүүн хэсэг боловч газар нутгийн хувьд маргаантай байга бүсийн төд байгаагаа ойлгохгүй байв. Тэднийг Халимагийн БНУ-ын Яшкул дүүргийн Кырояск мал үржүүлгийн төвийн захирал Бадма Есинович Гаряев явуулсан бөгөөд мужийн дарга хийж байсан тэрээр Халимагийн БНУ-ын хил дотор байсан тэр цагт энэ газрыг түрээслэсэн байна.

Энэхүү асуудал үүсээд байгаа энэ нутаг нь Астрахань муж болон Халимагийн БНУ-ын хоорондох ямар нэгэн зохицуулалтгүй хилийн бүс бөгөөд ОХУ-ын дээрх хоёр бүрэлдэхүүн хэсэг нь уг бүс нутгийг өөрсдийн газар нутагт хамааруулан авч үздэг байна.

Зурвиг Евгений Половский



Степной БНГ дахь монгол гэр.

Дэлхийн 2-р дайны үед ЗСБНХалимаг улс нь ЗСБНХОУ-ын Бүх оросын командлагчийн зарлигаар тусгаар тогтнолоо алдсан. Тэдний газар нутгийг хөрш зэргэлдээх мужууд хуваан авч, Халимагуудыг Сибирь руу цөлсөн юм. 1950-иад онд жижигхэн газар нутагт БНУ дахин тусгаар тогтнов. Өнөөгийн Степной БНГ-ийн байршил нь Астрахань мужийн хэсэг болон үлдсэн газар нутгийн нэг билээ. ЗСБНХУ задран унасны дараа ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүд энэ газар нутгийн төлөө дахин заргалдаж эхлэсэн. Халимагуудын заргаар 2001 онд муж дундын шүүх хуралдаж, тухайн нутгийн баруун хэсгийг Халимагт шилжүүлэхийг зөвшөөрсөн байна. ОХУ-ын Дээд шүүх 2003 онд эсрэг шийдвэр гаргав. Уг газар нутгийн статус өнөөдрийг хүртэл эргэлзээтэй хэвээр байна. Саяхан Халимагын БНУ болон Астрахань муж эвлэрлийн гэрээ байгуулсан.

Маргаантай газар нутгийн хагас цөлөрхөг хээрийн бэлчээр нь бөхөн хамгаалал ихээхэн чухал үүрэгтэй юм. Пре-Каспийн бөхөнгийн тоо толгой 1990-ээд оны сүүлээс эхлэн огцом буурч, өнөөдөр 1997 оны тоо толгойн 5%-тай тэнцэх амьтан л байна. Лиман мужийн баруун хэсэг нь мөн л дээрх маргаантай бүс нутагт хамрагдах бөгөөд уг нутаг нь бөхөнг хамгаалан үлдэхэд чухал ач холбогдолтой билээ. Энд томоохон сүргүүд тогтмол нүүдэллэн ирдэг бөгөөд эмэгчин бөхөнгүүд төллөх үедээ цуглардаг “төллөх нутаг” юм.

ОХУ-ын хоёр бүрэлдэхүүн хэсэг уг нутгийг бөхөн хамгаалах Халимагт Тингутинский, Астраханд Степной хэмээн нэрлэгдэх БНГ-ийг байгуулахаар шийдвэрлэсэн. Эдгээр БНГ-ын нутаг дэвсгэр нь бараг давхцдаг. Үнэндээ энэ газар нутаг Астрахань мужид харьяалагдсаар байгаа бөгөөд Степной БНГ-ын байгаль хамгаалагчид хамгаалсаар байна. Астрахань мужийн хууль журам ёсоор байгалийн нөөцийн менежментийн зөвшилцөл байхгүй нөөц газарт мал сүрэг бэлчээхийг хориглодог байна.

Уг нутагт үүнийг хориглох цөөн хэдэн шалтгаан бий. Нэгдүгээрт, бөхөн болон хонь, ямааны хооронд бэлчээрийн хүчтэй өрсөлдөөн бий болж, гэрийн мал намрын улиралд бөхөнгийн үндсэн байршил нутагт идээшилснээр бөхөнгийн сүрэг өвөл ч гэсэн ялгаагүй уг нутгаас дайжих нөхцөл бүрдэнэ. Хоёрдугаарт, малаа хариулж буй хүмүүс хууль бус ан хийх нөхцөл бүрдэнэ. Гуравдугаарт, өвчний дэгдэлт; гэрийн малын дунд гарсан халдварт өвчин нь тухайн бүс нутагт үлдсэн бөхөнгийн популяцийг сүйрүүлэхэд хангалттай юм. БНГ-т мал сүрэг өсгөх, үржүүлэх үйл ажиллагаа явуулах нь санаанд үл буух, хүлээн авч боломгүй зүйл нь ойлгомжтой билээ.



Зүрлийн Есенийн Полонский

Ус ууж байгаад үргэн зугтаж буй айсан бөхөнгүүд.



Зүрлийн Есенийн Полонский

**Зочломтгой, сайхан сэтгэлтэй монголын үхэрчид БНГ-т оршин сууснаараа дүрэм зөрчсөнөө таамаглаач үгүй явна.**

Одоогийн байдлаар Халимагийн БНУ-ын Байгалийн нөөцийн яамнаас албан ёсны тайлбар өгөөгүй байна. Байгалийн нөөцийн яамны ажилтан Владимир Бадмаевын өгсөн албаны бус тайлбар өгөхдөө: “Черные Земли БНГ [Степной БНГ-тай хил залган Халимагт улсын түвшний ЮНЕСКО-гийн Биосферийн БНГ] газар нутгийнхаа энэ хэсгийг нэгдсэн улсын мэдэлд шилжүүлэн өгсөнөө албан ёсоор мэдээлсэн боловч Астрахань энэ шилжүүлгийг зохицуулаагүй байна. Үүний улмаас БНГ шалдаа буутлаа доройтсон. Маргаантай газар нутгийн бүс нутгийн нэгдлийн тухай одоогийн үүссэн маргаанд үндэслэн улсын мэдэлд энэ газрыг шилжүүлэн, Черные Земли Биосферийн нөөц газрыг өргөтгөх нь өнөөгийн байдлаас гарах хамгийн тохиромжтой арга зам байх болно” гэж хэлсэн.

Астрахань мужийн захирагч Константин Маркелов 8 сарын 15-нд үүссэн нөхцөл байдалд тайлбар хийхдээ: “Өнөөдөр Зэрлэг амьтан хамгаалах газрын албан хаагчид, цагдаагийнхан хууль бус бүтээн босголт хийсэн газарт очиж байна. Халимагийн БНУ-ын мужийн засаг захиргаа хууль бусаар түрээслүүлсэн явдал нэгэнт тодорхой боллоо. Засаг захиргаанаас баталсан хууль тогтоомжийн дагуу ОХУ-ын нэг бүрэлдэхүүн хэсгээс нөгөө бүрэлдэхүүн хэсгийн нутаг дэвсгэрт гадаадын иргэн оршин суух тухай, Байгаль хамгаалах тухай хууль тогтоомж зэрэг дор хаяж хоёр хууль зөрчсөн байна. Ойрын үед цагдаагийн төлөөлөл, Улсын цагаачдын алба, мужийн болон орон нутгийн засаг захиргаа хамтран Астрахань мужид эдгээр хууль бус үйл ажиллагааг хянахын тулд арга хэмжээ авч хэрэгжүүлэх болно. Би Халимагийн БНУ-ын тэргүүн И.А.Зотовд анхааруулж байсан. Эдгээр хууль бус үйл ажиллагаагаа зогсоох талаар чармайлт тавьж ажиллахыг би хүссэн. Нөхцөл байдал Астрахань мужийн засаг захиргааны хяналтанд байгаа” гэжээ.

Үүний дэлгэрэнгүй хувилбарыг доорх холбоосоор орж үзэх боломжтой.

<http://strana.ru/journal/news/23202710>.

**Редакторын тэмдэглэл:** БНГ-т үлдсэн оршин суугчдын талаарх баталгаажуулалт мэдээлэл бидэнд байсаар байна.:

<http://e-polonskiy.livejournal.com/237266.html>.

Өнөөг хүртэл албан ёсоор баталгаажуулалтгүй байна.

# Узбекистанд 2006-2012 онд бөхөнгийн мониторинг хийсэн мэдээллийн анализ

Эмма Марсден<sup>1</sup>, Александр Есинов<sup>2</sup>, Елена Быкова<sup>2</sup>, Е.Ж. Милнер-Гулланд<sup>1</sup>

1. Лондонгийн Эзэн хааны коллеж.

2. Амьтан, ургамлын генетик нөөцийн хүрээлэн, Узбекистаны ШУА.

Холбогдох зохиогч: Е.Ж. Милнер-Гулланд, [e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)

Узбекистаны бөхөнгийн мониторинг судалгааг гурван гол арга зүй буюу эрдэмтдийн экспедицийн тохиолдлын мониторинг, орон нутгийн ард иргэдийн тохиолдлоор харах боломжинд тулгуурласан оролцооны мониторинг, 2012 оноос хэрэгжүүлж эхлэсэн орон нутгийн оршин суугчдыг тодорхой трансектын дагуу мотоциклоор явуулах зэрэг ашиглан 2006 оноос хойш хийж байна. Бид Узбекистаны бөхөнгийн тархалтын чиг хандлага улирлаар болон орон зайн хувьд хэрхэн өөрчлөгдөж байдгийг харахын тулд эдгээр бөхөнгийн ажиглалтын цэгэн мэдээлэлд анализ хийсэн.

VI-IX сард цөөн тооны ажиглалт хийгдсэн тул дээрх саруудын ажиглалтын мэдээллийг анализаас хассан. Мөн 2005 оны 12 сарын цөөн ажиглалтын мэдээлэл нь Узбекистанаас илүүтэйгээр Казахстаны нутаг дэвсгэрт тэмдэглэгдсэн байсан тул анализаас хассан (бүх цэгүүд төмөр замын дагуу тэмдэглэгдсэн байсан учир хассан). Бидний анализд нийтдээ 186 ажиглалтын мэдээлэл хамрагдсаны 15 нь тохиолдлын мониторингийн, 147 нь оролцооны мониторингийн, 24 нь 2012 онд хийсэн трансектын явцад цуглуулсан цэг байв. Устюртын тал нутгийн энд тэндгүй тэмдэглэгдсэн байсан ба эдгээр ажиглагдсан цэгүүд нь тухайн жилийн улирлаас шалтгаалан ялгаатай байсан (Хүснэгт 1, График 1).


Дээжийн хэмжээ бага, хээрийн судалгааг гүйцэтгэсэн хугацаа (өөрөөр хэлбэл хүйтэн өвөл биш, халуун зун биш) болон мониторинг судалгааны аргыг ажиглагч тухайн нутагтаа тохируулан хэрэглэсэн (трансект хийх нутагаас хол зайд) зэргээс хамааран хязгаарлагдмал мэдээлэл цугларав. Бөхөн ажиглагдсан цэгийн байршлыг шалгаж үзэхэд замын ойролцоо илүү өндөр нягтшилтай гарчээ.

(Wilcoxon signed rank test;  $V=4542$ ,  $p<0.001$ ). Эсрэгээр бөхөнгүүд нь хнү амын суурьшилтай газруудад цөөн тоогоор ажиглагдсан (Wilcoxon signed rank test;  $V=17319$ ,  $p<0.001$ ) бөгөөд энэ нь оролцооны болон трансектын мониторингт тулгуурлан гаргасан бодитой зүйл билээ. Тухайн цэгт судалгаа хийсэн ажиглагчийн хандлага, судлаачийн явсан замлалын дагуух трансектын мониторинг учраас илүү задгай газар луу зугтаах бөхөнгийн жинхэнэ зан төрхтэй холбоотойгоор эдгээр үр дүн нь хир зэрэг өөрчлөгдөхийг хэлэх боломжгүй бөгөөд иймээс ажиглагдаагүй боловч бөхөнгийн судалгаа хийгдсэн нутгийг мөн хамруулж үзсэн. Гэсэн ч зарим чухал ач холбогдолтой дүгнэлтүүдийг хийж болно.

График 1-ээс харвал бөхөн нь Устюртын тал нутагт жилийн турш түгээмэл тархацтай байдгийг харж болно. Жилийн туршид бөхөн байдаг тал нутгийн баруун өмнөд хэсэг нь ихээхэн ач холбогдолтой байгаа нь сонирхолтой юм. Хэрвээ Казахстанас энэ нутаг руу бөхөнгүүд нүүдэллэн ирэх замдаа төмөр зам болон засмал замыг хөндлөн гарч, бүс нутгийн томоохон хотыг дайран өнгөрөх учир энэ нь боломжгүй зүйл билээ. Мөн уг нутаг нь хамгаалалтанд авахаар төлөвлөсөн Сайгачий хамгаалалттай нутагт хамрагддаггүй учир эдгээр бөхөнгүүд хулгайн агналтанд өртөх эрсдэл өндөр юм. Энэ нь цаашид уг газар нутгийг ажиглах, бөхөнгийн нутагших уу эсвэл үгүй юу гэдгийг тодорхойлох нь ихээхэн чухал ач холбогдолтой. Узбекистанд төллөх үедээ болон зуны эхээр

Хүснэгт 1. Жил бүрийн бөхөнгийн ажиглалтын тоо болон ашигласан мониторинг арга

Жил	Ажиглалтын тоо	Ашигласан арга
2006	11	Тохиолдлын
2007	28	Оролцоо
2008	42	Оролцоо, Тохиолдлын
2009	29	Оролцоо
2010	37	Оролцоо
2011	12	Оролцоо
2012	27	Трансек, Тохиолдлын



Зураг 1. Устюртын тал нутгийн Узбекистанд хамрагдах хэсгийн газрын зурагт 3 өөр судалгааны хугацаанд ажиглагдсан бөхөнгүүд: 1-р үе (X-XII сар, ногоон), 2-р үе (I-III сар, улбар шар), 3-р үе (IV-VI сар, улаан).

өвлийн улиралд байршиж байгаа нь тодорхой болсон. Бөхөнгүүд нь X-III сард байдгаасаа илүүтэйгээр IV-VI сард Казахстаны хилийн ойролцоо илүү их тохиолдож байна. (Kruskal-Wallis test,  $\chi^2 = 17.11$ ,  $df = 2$ ,  $p\text{-value} < 0.001$ ).

Бид 186 ажиглалтын мэдээлэл дээр үндэслэн бөхөнгийн хамгийн их ашиглаж байгаа газар нутгийг тодорхойлохын тулд Maxent загварыг ашигласан бөгөөд хувсагч утгад хот тосгон хүртэлх зай, цасан бүрхэвчийн зузаан, NDVI, температур зэргийг ашигласан (Эмма Марседений магистрын зкэрэг горилсон бүтээлээс доорх холбоосоор орон [//www.iccs.org.uk/publications/thesis-archive-general/](http://www.iccs.org.uk/publications/thesis-archive-general/) илүү дэлгэрэнгүйг үзэж болно). Үр дүнгээс үзвэл бөхөнгийн хамгийн их ашиглаж буй нутаг нь Сайгайчи БНГ-г өргөтгөхөөр төлөвлөсөн газартай давхцан оршиж байна. Узбекистаны Устюртын тал нутгийн бөхөнгийн мониторинг судалгаа нь боловсон хүчний дутагдалтай байгаа, цаг уурын хүнд нөхцөл, хязгаарлагдмал санхүүжилттэй зэрэг байдал нь эргэлзээтэй байдалд хүргэж байна (С.Оффордын өгүүллийг БМ №14-өөс хар). Үүнийг тооцон үзвэл хязгаарлагдмал мэдээлэл цугларч байгааг ойлгоход гайхах зүйлгүй бөгөөд тайлбарлахад хэцүү юм. Тохиолдлын мониторинг нь бодит мониторинг хөтөлбөрийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой боловч бий болгосон мэдээллийн сан нь мэдээллийн дутагдалтай байдлаас шалтгаалан бөхөнгийн тархацын анализ хийхэд хангалтгүй юм. Оролцооны мониторинг судалгаагаар ихэнх цэгэн мэдээллийг олж авсан боловч го дутагдал нь зохион байгуулалт, дэс дараалалтайгаар хийгдээгүй байна. Трансекстын мэдээлэл нь анхлан хийсэн судалгаагаар цуглуулсан цөөн тоотой ажиглалтын мэдээллээс бүрдэх учир хангалттай хэмжээнд анализ хийж чадахгүй боловч хэрвээ үүнийг үргэлжлүүлэн хийвэл цаашид ихээхэн ач холбогдолтой байх болно. Учир нь ажиглагчийн зүгээс гаргах алдаа багатай, судалгааны үр дүнг тоон хэмжээгээр тодорхойлох боломжтой байдаг байна. Энэ бүх хязгаарлалтыг үл харгалзан үзвэл энэхүү анализ нь Узбекистаны бөхөнг хамгаалахын тулд Сайгайчи БНГ-ыг өргөжүүлэх ач холбогдолтойг харуулж



Зургийг Виттор Григорьев

### Арал тэнгисийн эрэгт бөхөнгийн сүргийн ул мөрийг оллоо.

байгаа бөгөөд Узбекистаны Устюртын тал нутагт бөхөн нь өмнө тодорхойлогдож байснаас илүү удам нутагт орон зай, жилийн турш байршин амьдарч байна. Гол зөвлөмж нь трансектын мониторинг судалгааг эрчимжүүлэн, өргөжүүлэх асуудал бөгөөд төмөр замын газар доогуурх болон дээгүүрх нутгийг хамруулах, хамгааллын төлөвлөгөөг боловсруулах ажил юм. Энэхүү мониторинг хөтөлбөрөөр үүсэн бий болсон мэдээлэл нь Узбекистаны бөхөнг үр дүнтэй хамгаалах гарын авлага болох төдийгүй хамгаалалттай газар нутгийг төлөвлөх, байгаль хамгаалагчдыг байршуулахад ашиглагдах болно. Энэхүү ажлыг ивээн тэтгэсэн Байгаль хамгаалах Витлейн сан болон Олон улсын Амьтан, ургамлын аймгийг хамгаалах санд талархал илэрхийлье.

## Казахстаны Иргыз-Тургай БНГ-т хийгдэж буй бөхөнгийн мониторинг

Жаннур Бакытзанкызы

Иргыз-Тургай БНГ, [zhannur\\_85@mail.ru](mailto:zhannur_85@mail.ru)

Иргыз-Тургай БНГ нь Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн хэсэгт хамаарах бөгөөд тархац нутгийн хэмжээ болон бөхөнгийн тоогоороо томоохон популяцийн нэгд ордог. Иргыз Тургай БНГ Актюбинск мужийн өмнө хэсэгт орших бөгөөд “Атанбасы” болон “Алакол” гэсэн 2 хэсгээс тогтох ба тэдгээрийн хооронд мөн улсын нөөц газар ангиллаар хамгаалагдсан Тургай хамгаалалттай газар оршдог [хамгааллын доод түвшин бүхий нөөц газар] (Зураг 1). Нийт 1,059,549 га талбай хамрагдана.

Уг нөөц газар нь бөхөн хамгаалалд чухал үүрэгтэй. Хавар төллөх үеэр бөхөнгүүд нь жижиг сүргийн хэлбэрээр хэдэн газарт (Куланай, Сунларкиа, Косбурек) төвлөрдөг. Энэ популяцийн нүүдэллэх ерөнхий чиглэл нь нөөц газрыг дайран, хаврын улиралд өмнө зүгээс хойд зүг рүү, намрын улиралд хойд зүгээс өмнө зүг рүү нүүдэллэдэг. Нүүдлийн үед бөхөнгийн 80-90% нь зүүн зүгт Шалкар-Тэнгизийн давст нуурыг чиглэдэг бол цөөн тоотой хэсэг нь баруун тийш чиглэн



Зургийг И. Закинов

Жаннур Бакытзанкызы шинээр төрсөн янзаганы хамт.

нүүдэллэдэг. 2012 онд хаврын нүүдэл II сарын сүүлээр эхлэж, III сарын сүүлээс IV сарын эхэн хүртэл үргэлжилсэн. Намрын нүүдэл X сард эхлэж, XI, XII сард дууссан. Улирлын нүүдэлтэй давхцан бөхөнгийн сүрэг өвсний соргог, уст цэгүүдийг хайн жилийн турш нэг газраас нөгөө рүү шилждэг. 2011 оны 1 сарын 1-ний байдлаар уг нөөц газарт 33000 гаруй бодгаль байсан бол 2012 оны 1 сарын 1-нд 25%-иар өсөж, 42000 гаруй бодгаль байршиж байв. (Хүснэгт 1).

2012 оны 11 сард хийгсдэн газрын трансект тооллогоор 17 болон 712 бөхөн нөөц газрын зүүн өмнөд хэсэгт ажиглагдсан. 2012 оны 12 сард нөөц газрын хойд хэсэгт (Алакол) 15000 орчим бөхөн байсан бол Косбуйрек уулын орчим 2000 бөхөн, зүүн өмнөд хэсэгт (Айырмола, Атанбасы, Зынгылдиозек, Тегене) 20000 бөхөн байв. 2012 оны өвөл бөхөнгийн ороо хөөцөөн нөөц газрын хэд хэдэн хэсэгт




**Зураг 1.**  
Иргы́з-Ту́ргай БНГ-ын өнөөгийн газар нутаг болон өргөтгөхөөр төлөвлөж буй хэсгийн зураг.

**Хүснэгт 1.** Иргы́з-Ту́ргай БНГ-т бөхөнгийн нягтшил, 2012.


	Нийт нутаг	Газрын нэр		
		Алакол	Заказник	Атанбасы
Нутаг дэвсгэр (га)	1 059 544	88 180	296 000	675 369
Бөхөнгийн тоо	42162	8250	6 200	27 712
Популяцийн нягтшил (/1000 га)	39.8	93.6	20.9	41.0

12 сарын 10-20-ны хооронд явагдав (Зураг 2). Морин шарилжагд өвс-хужир өвст ургамалжилттай, заг ховор, татар бажууна элбэг тохиолдох дунд зэргийн хэрчигдэл бүхий нутагт 5 сарын 10-наас 20-ны хооронд төлөлт явагдсан (Зураг 3). Нийт 252 янзагатай шаргачин болон 184 янзага харагдсан бөгөөд дунджаар 1 эмэгчинд 0,7 янзага ноогдож байв.

Дээрх мэдээллээс харвал Иргы́з-Ту́ргай БНГ нь бөхөнгийн өвлийн байршил нутаг бөгөөд зуны улиралд харьцангуй багасах ба ороо хөөцөөнд орох, төллөх нутаг болно. БНГ дахь бөхөнгийн тоо толгой идэш тэжээлийн чанар, ундаалах усны олдц зэргээс хамааран жил, улирлаар хэлбэлзэнэ.




**Зураг 2.** Иргы́з-Ту́ргай БНГ-ын бөхөнгийн өвлийн тархац, 2012.




**Зураг 3.** Иргы́з-Ту́ргай БНГ-ын бөхөнгийн хаврын тархац, 2012.





Зураг 4. Иртыш-Тургай БНГ-ын бөхөнгийн зуны тархац, 2012.



Зураг 5. Иртыш-Тургай БНГ-ын бөхөнгийн намрын тархац, 2012.

## Пре-Каспийн бөхөнгийн популяцийн статусыг үнэлэхэд хамтын оролцооны мониторингийг ашиглах нь

Леежиах Дорвард<sup>1</sup>, Юрий Арылов<sup>2</sup>, Е.Ж. Милнер-Гулланд<sup>1</sup>

1. Лондонгийн Эзэн хааны коллеж. 2. Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төв.  
Холбогдох автор: Леежиах Дорвард, [leejiah@gmail.com](mailto:leejiah@gmail.com)

### Оршил

Пре-Каспийн бөхөнгийн популяци нь дэлхийн популяцийн хандлагыг даган 1950-иад онд 800000 орчим байснаа 2001 онд 15-20000 болж буурсан. Сүүлийн үеийн үнэлгээгээр буюу 2012 онд 7000 байсан (БМ-16-аас хар) ба популяцийн хэмжээ үргэлжлэн буурсаар байгаа болно. Гэсэн хэдий ч өнөөгийн популяцийн хэмжээ, хандлага болон тархалтын байдал үндсэндээ тодорхойгүй байна.


Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төв 2008 оноос эхлэн 3 хамтын оролцооны мониторинг төслийг эхлүүлсэн нь; Их Британы консулын газар, BRIDGE хөтөлбөрөөс санхүүжсэн 2008 оны III-2009 оны XI сар хүртэл үргэлжилсэн төсөл; Руффордын сангаас санхүүжин 2010 оны X сараас 2011 оны VI сар хүртэл үргэлжилсэн төсөл; АНУ-ын Загас болон Зэрлэг амьтан хамгаалах холбооноос (USFWS-ЗЗАХХ) санхүүжсэн 2012 оны II-XI сар хүртэл үргэлжилсэн төслүүд юм. BRIDGE болон Руффордын сангийн төсөлд 25 хүн ажилласан бол ЗЗАХХ-ноос санхүүжсэн төсөлд 43 хүн ажиллаж басны зарим нь өмнөх төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байв. Судлаачид тохиолдлын байдлаар бөхөнгийн тоог (ажиглагдсан бөхөнгийн тоо, ажиглагдсан он сар, цаг, хүйс, ажиглагчаас амьтан хүртэлх зай, өнцөг, бусад тайлбарууд) тодорхойлохоор ажиллаж байв.

Ажиглагчид судалгааны үр дүнг хэмжээгүйн улмаас хэдийгээр популяцийн өөрчлөлтийн статусыг тогтооход ашиглаж болох олон тооны судалгааг гүйцэтгэсэн ажиглагчдын цуглуулсан сүргийн хэмжээ, ажиглагдсан давтамж зэрэг мэдээллээс харьцангуй буюу үнэмлэхүй нягтшилыг тооцоход учир дутагдалтай байна (жил бүр ажиглагчдын судалгааны үр дүн ижил байсныг авч үзвэл). Бөхөн ажигласан болон ажиглаагүй судлаачдын ажиглалтын мэдээг харьцуулан байгаа/байхгүй (presence/absence) мэдээллийг ашиглан бөхөнгийн тархалтын өөрчлөлтийг гаргаж болох юм.

### Сүрэглэлтийн байдлын өөрчлөлт

Жил бүрийг сүрэглэлтийн хэмжээнээс хамаарч хавар (1-122 өдөр), зун (123-244 өдөр), өвөл (244-365 өдөр) гэсэн 3 улиралд хувааж үзсэн. Зуны үед сүрэглэлтийн хэмжээ хавар болон, өвлийнхөөс харьцангуй бага байна ( $\chi^2=46.2$ ,  $p<0.001$ ; Зураг 1). Хаврын улиралд үүсэх сүргийн хэмжээ жилээс хамааран харилцан адилгүй байсан ( $\chi^2=12.0$ ,  $p=0.008$ ) ба 2008 ба 2009, 2010 ба 2011 ба 2012 онуудын хооронд ялгаатай байна. Зун болон өвлийн сүрэглэлтийн хэмжээнд онцгой ялгаа харагдаагүй (Зураг 1).

Том хэмжээний газар нутагт олон тооны судлаачид оролцсоныг үл харгалзан үзвэл 2012 онд сүргийн дундаж хэмжээ болон хамгийн их утга бусад онуудтай харьцуулахад багассан байна (Хүснэгт 1).



Зураг 1. Оролцооны мониторинг ашиглан цуглуулсан бөхөнгийн сүргийн хэмжээ жил, улирлаар ялгаатай байдал

Өөр өөр жилийн ялгаатай улиралд харилцан адилгүй газар нутгийг хамруулан хийсэн судалгаагаар дээрх статистикийг өгч байгаа бөгөөд үүнээс 2012 онд томоохон сүргүүд алга болсоныг тэмдэглэж байна.

Өмнөх бүх жилүүдийн нийлбэр болон 2012 оны хаврын сүрэглэлтийн хэмжээ маш их хэмжээгээр багассан байна ( $W_{255}=6175$ ,  $p=0.0012$ ). Харин олон жилийн зуны сүргийн ялгаа бараг байхгүй байна ( $W_{185}=3249$ ,  $p=0.52$ ). Өвлийн сүргүүдийн хэмжээ 2012 онтой харьцуулахад их гарсан байсан боловч энэ ялгаа нь нөлөөлөхүйц их биш юм ( $W_{259}=3536$ ,  $p=0.086$ ).

Холимог хүчин зүйлийн шугаман загвар нь нэгээс илүү жил ажиглалт хийсэн судлаачдын сүргийн хэмжээг харьцуулахад ашиглагдсан. Энд харуулсан сүргийн дундаж хэмжээ нь 2008-2009 онд өссөнөө 2010 онд 2008 онд байсан хэмжээнээс доогуур утгатай тэмдэглэгдсэн бөгөөд 2011 болон 2012 онд үргэлжлэн буурсан байна. 2009 он (сүргийн хэмжээ их байсан) болон бусад бүх жилийн хоорондох сүргийн хэмжээ ялгаатай байсан.

#### Ажиглалтын тоо Сараар өөрчлөгдөх нь

Олон төсөлд оролцож байсан судлаачдын бөхөнтэй тааралдах давтамж өөрчлөгдөж байгаа нь ажиглагдсан бөгөөд хэрвээ жилээс жилд мониторинг судалгааны үр дүн ижил байсан юм бол цөөн сүрэг бүхий нутагт цөөхөн бодгаль тааралдана хэмээн ойлгож болно. BRIDGE болон ЗЗАХХ-ны төслийн аль алинд нь оролцож байсан найман судлаачийн сар тутмын ажиглалтын тоо нь 2008/2009 онд сард дунджаар 1,6 ажиглалж байснаа 2012 онд 0,5 болж буурсан байна ( $V_8=26$ ,  $p=0.047$ ). Руфффорд болон ЗЗАХХ-ны төслийн аль алинд нь оролцож байсан 20 судлаачийн хувьд 2010/11 онд 0,89 байснаа 2012 онд 0,32 болж буурчээ ( $V_{20}=188$ ,  $p=0.0002$ ).

#### Бөхөнгийн тархац нутгийн өөрчлөлт

2008-2012 оны хугацаанд бөхөнгийн тархац нутгийн




Зургийг Леежиах Дорваро

Янзагатай эмэгчинг олж харах үед маш түргэн зугтааж байна.

### Хүснэгт 1. Сүрэглэлтийн хамгийн их ба дундаж утга (95% confidence intervals), ажиглагдсан сүргийн нийт тоо болон хамтын оролцооны мониторинг хийсэн жил бүрийн идэвхтэн судлаачдын тоо. Бүх жилийн туршид хамгийн бага сүргийн хэмжээ 1 байсан.

Жил	Сүрэглэлтийн хамгийн их утга	Сүрэглэлтийн дундаж утга	Ажиглалтын тоо	Судлаачын тоо
2008	2000	32±11	222	25
2009	4500	544±440	46	25
2010	800	48±13	89	25
2011	6500	86±32	220	25
2012	30	7±0.45	122	43



Зураг 2.

BRIDGE (2008/2009), Руфффорд (2010/2011), ЗЗАХХ (2012)-оос хэрэгжүүлсэн төсөлд хамрагдсан ялгаатай бөхөнгийн тархац нутгийг харуулж байна.

Цэгээр ЗЗАХХ-ны төслийн ажиглагчдын хийсэн ажиглалтын цэгийг, өнгөөр ялган хамгийн сүүлд харсан бөхөнгийн байршлыг оруулав.

өөрчлөлтийн бага зэрэг ялгаатай байдлыг тэмдэглэв (Зураг 2). Нэгээс илүү төсөлд оролцсон судлаачдын дийлэнх нь хоёр төслийн явцад бөхөн харсан байна ( $n=24$ ). Руфффордын төсөл хэрэгжих үеэр бөхөн харсан 4 судлаач ЗЗАХХ-ны төсөл хэрэгжих үед бөхөн хараагүй бол, судлаачтай ойрхон амьдарч байсан хүмүүс 2 төслийн явцад бөхөн харжээ (5.7 болон 12.1 км зайд орших).

#### Дүгнэлт, санал зөвлөмж

Жилүүдийн хоорондох сүрэглэлтийн хазайлтын дээд хэмжээнд хяналтын талбайн байршлын өөрчлөх нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байна (Зураг 1). BRIDGE болон ЗЗАХХ-ноос хэрэгжсэн төслийн үед судалгаа хийж байгаагүй боловч Руфффорд төслийн үед ажиллаж байсан 5 хүн 2010 болон 2011 онд томоохон сүргүүдийг тэмдэглэж, хамгийн их тогтмол ажиглалт хийж байсан. Тэд Степной болон Зерные Земли БНГ-ын өмнөд хэсэгт бөхөнгийн үндсэн тархац нутагт аьдардаг байна. ЗЗАХХ-ны төсөл биш, харин Руфффордын төсөлд оруулсан тэдний хувь нэмэр нь хоёр төслийн хоорондох сүрэглэлтийн эрс ялгаатай байдлыг харуулахаас гадна хүн амын хандлагыг үнэн зөв таамаглах бидний чадвар сул байгааг ажиглаж болох юм. Гэсэн ч энэ анализаас 2012 онд бөхөнгийн популяцийн хэмжээ өмнөх жилүүдийнхээс бага байгааг харж болно.

# Узбекистаны Устюртын тал нутгийн ховор туруутны хууль бус агналтын түвшин

Елена Быкова, Александр Есипов

Амьтан, ургамлын генийн нөөцийн хүрээлэн, Узбекистаны ШУА  
Бөхөн хамгаалах нийгэмлэг, [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)

Узбекистаны Устюртын өндөрлөгт 3 зүйлийн ховор туруутан амьтан оршин амьдарч байна. Тэдгээр нь бөхөн (*Saiga tatarica*), хар сүүлтий (*Gazella subgutturosa*) болон Устюртын улаан хонь (*Ovis vignei [orientalis] arkal*) юм. Орон нутгийн иргэдийг хамруулан хамтын оролцооны хөтөлбөрийн хэсэг болгон бид Амьтан, ургамлын аймгийг хамгаалах олон улсын сан, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний дэмжлэгтэйгээр орон нутгийн хүмүүсээс авсан аман судалгаанд тулгуурлан хуурь бус агнуурт өртсөн амьтдын тоог үнэлэхийг оролдсон. Үр дүнгээс үзвэл 250 бөхөн (76 эр, 174 эм), 22 хар сүүлтий, нэг улаан хонь 2009 оны X сараас 2012 оны XII сар хүртэл хууль бусаар агнагдсан байна. Хууль бус агнуурын эрчмийг үнэлэхийн тулд анчдын нэг багийнхны (нэг мотоцикл, хоёр хүн) нэг жилийн хугацаанд (2010 оны V сараас 2011 оны IV сар хүртэл) агнасан бөхөн болон хар сүүлтийн тоонд анализ хийв.

Эндээс дүгнэн үзвэл Зүүн болон Зүүн Өмнөд Азийн хар зах дээр эрэлттэй байх эрэгчин бөхөнг агнах нь хулгайн анчдад туйлын чухал байдаг байна. Эрэгчин амьтны наснаас хамаарахгүйгээр нэг настай амьтныг хүртэл агнадаг байна. Бие гүйцсэн эмэгчинг махны зорилгоор агнана. 2013 онд 1 кг цэвэр бөхөнгийн эврийн үнэлгээ 1,000,000–1,500,000 сөм (\$370-550); мах нь 9,000-10,000 сөм/кг байсан нь үхэр, хонь, тэмээний махнаас 1,5 дахин хямд юм. Хар сүүлтийг зээрийг гол төлөв махны зорилгоор агнадаг.

Үүний зэрэгцээ орон нутгийн иргэд бөхөнгийн эвэртэй адилхан тэдгээрийн эврийг ашиглахаас гадна трофейн болон тахин шүтэх зорилгоор агнадаг.

Хар сүүлтий ховордон Устюртын тал нутгийн ихэнх тосгодоос алс зайтай нутагт байршдаг болсон үеэс зөвхөн орон нутгийн иргэд агнасаар ирсэн бөгөөд бөхөн агнууртай адилхан энэ зүйл амьтан тийм их агналтанд өртдөггүй.

Агналт нь бөхөнгийн нүүдлийн үед илүү эричмтэй явагддаг гэсэн нийтлэг ойлголтыг сөргүүлэн үзвэл бидэнд байгаа мэдээлэл нь агнуурын үйл ажиллагаа бүтэн жилийн турш нэг хэвийн хэмжээнд үргэлжилдэг байна. Хулгайн анчид байгаль цаг уурын нөхцөл (хэт хүйтэн, гүн цас, бороо, болон



Зургаа Александр Есипов

## Каракалпакстан тосгоны ойролцоогоос олдсон эврийг хөрөөдөж авсан бөхөнгийн гавлын яс.

хэт халуун биш үед), хүний зүгээс үзүүлэх шалтгаан (мөнгө, эрүүл мэнд гэх мэт) зэргээс хамааран сард 1-9 удаа агнуур хийдэг байна. Бидэнд байгаа мэдээллээс харвал тодорхой нөхцөлд агнуур нь 10 сар гаруй үргэлжилдэг байна (2011 оны I сард биш, хүйтэн өвөл, хүний шалтгаанаас үүдэн III сараас). Нийт 46 аялал хийж, үүнээс 4 аялалын явцад бөхөн хараагүй байна. Үлдсэн 42 аялалын явцад бөхөн харж, тэдгээрийг агнах оролдлого хийснээс 30 нь амжилттай болжээ. Эдгээр аялалуудын дундаж зай 290 км байсан. Анчидтай нийцүүлэн үзвэл өнгөрсөн хугацаанд тэд бөхөн агнахыг гол зорилго болгон хол газар явах хэрэгтэй байв. Дунджаар хулгайн анчид өөрсдийн харсан бөхөнгийн 47%-ийг агнаж байв. Анчдын ур чадвар, байгалийн хүчин зүйлийн (рельеф, хөрсний чанар) зэрэгцээ агнуурын үр бүтээмж нь тухайн анчны зан чанараас хамаарна (зарим анчид нэг наснаас бага амьтныг болон хээлтэй амьтныг агнахыг цээрлэдэг). Нэг ан хийх аялалын явцад хамгийн их бөхөн агнасан нь 10, дунджаар 3,9 байсан. Сар бүр тэд 3-39 бөхөн, дунджаар 11 бодгалийг агнаж байв. 2010 оны V сараас 2011 оны 4 сар хүртэлх хугацаанд зөвхөн нэг багийн агнасан бөхөнгийн нийт тоо 132 (39 эр, 93 эм) болж байна. Узбекистаны хүмүүс Казахстаны хилийн бүс рүү орж ан хийдэг болох нь батлагдсан. Дээрх хугацаанд хулгайн анчид ихэвчлэн IV-VIII сарын хугацаанд 18 хар сүүлтий (7 эр, 11 эм) агнасан байна. Узбекистанд бөхөн ховор байх зуны урин дулаан цагт, эсвэл бөхөнтэй адилхан хугацаанд агнагдсан хар сүүл байх магадлалтай. Хар сүүлтийн хувьд олж харсан 10 амьтны 9-ыг агнаж байжээ. Бидэнд буй мэдээлэл нь хязгаарлагдмал тооны хүмүүсээс цуглуулсан учир хулгайн ангийн бодит түвшинг тогтоох боломжгүйг хэлэх хэрэгтэй. Гэсэн хэдий ч хууль бус агнуур нь үргэлжилсээр буйг баталж байгаа бөгөөд хууль бус агнуурын үечлэл, үр бүтээмжийн талаарх санааг өгөхийг зорилоо.



Зургаа Александр Есипов

Хулгайн анчид.

# Бөхөнгийн баатар



Зургийг Виктория Клуднева

Анатолий ХЛУДНЕВ, Астрахан мужийн Степной БНГ-ын дарга. Анатолий Оросын зэвсэгт хүчинд офицер байсан ба тэрээр тэтгэвэрт гарсан дэслэгч хурандаа. Сүүлийн 10 жилийн туршид өөрийн бүх амьдрал, сэтгэл зүрхээ баруун хойд пре-Каспийн бүс нутгийн тал хээрт буй цорын ганц туруутан болох бөхөнг хамгаалахад зориулж явна.

Английн кино багийнханы эрдэм шинжилгээний зөвлөх байсан. Бид хүүхдүүдийг бага үеэс нь байгаль дэлхийг хайрлан хамгаалах зан чанарыг төлөвшүүлбэл бид ирээдүйд ялах учраас сургуулийн хүүхдүүдийг оролцуулсан аялалыг тогтмол зохион байгуулдаг. Жил бүрийн хавар Их Британи, герман, Австри, Швейцар зэрэг орноос ирсэн гадаадын жуулчдад зориулсан аялал зохион байгуулдаг.

**Редактор: Бөхөнгийн тухай ямар нэгэн сонирхолтой түүхийг бидэнтэй хуваалцана уу?**

**А.К.:** Тэгэлгүй яахав!!!! Маш олон түүхүүд байгаагийн ихэнх нь намайг дөнгөж ажлаа авсаны дараахан надад харагдаж, намайг алмайруулж байсан. Жирийн нэг өдөр би бие гүйцсэн бөхөн хэрхэн өөрийн бага залуу насныхныг халамжилж буйг нүдээрээ харсан. Энэ нь залуу бөхөнгүүд “гарах” үе буюу VI сард байв. Яг л “цэцэрлэг шиг” бяцхан янзагуудаа дагуулсан, мөн араасаа 5-6 бие гүйцсэн эрэгчин бөхөн дагуулан эмэгчээр удирдуулсан сүрэг нөөц газраар хэрэн хэсэж байсан. Тэдгээр эрэгчингүүд янзагануудыг хоцрох болон гээгдэхээс сэргийлэн явж байсан бөгөөд ядарсан янзагыг тэд хошуугаар болгоомжтой гэгч өргөн замд нь оруулж, тэдгээрийг халамжилж байв. Тухайн сүргийн дахин дахин харсаны дараа би тэдгээр эрэгчинг “асрагч эхүүд” гэж нэрлэсэн.

**Редактор: Танай ажилд тулгарч байгаа томоохон асуудал юу вэ?**

**А.К.:** Манай хамгийн гол асуудал нь Халимагийн БНУ-ын хүрээлэн буй орчныг хамгаалах газартай холбоо харилцаа сул байгаа мөн, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар голлон анхаарч байна.

**Редактор: Эдгээр саад тотгорыг хэрхэн арилгаж чадах вэ?**

**А.К.:** Би байгаль хамгааллын асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэж болох асуудал гэж найддаг, гэхдээ тэд бүс нутгийн юмуу түүнээс дээд түвшинд Астрахань болон Халимагийн БНУ-ын албан тушаалтнууд шийдвэрлэх ёстой.

**Редактор: Та бөхөнг анх хэзээнээс сонирхож эхлэсэн бэ?**

**А.К.:** Би бөхөнгийн тухай хүүхэд ахуйдаа сонсож байсан боловч гайхалтай тохиолдлоор тэднийг анх удаа 7 дугаар ангид байхдаа харж байв. Тэр өдөр маш сайхан байсныг санаж байна. Би өвлийн загасчлал хийхээр явж байсан багийн бүрэлдэхүүнд байсан. Бүгд уулын хяр дээр маш хурдан гарч ирсэн хэсэг амьтаттай тулгарч насанд хүрэгсэд бүгд “Бөхөн” хэмээн дуу алдсан. Би 500 гаруй тооны, “өвлийн хувцсаа” өмссөн тэдгээр амьтдын харахыг маш хичээж байв. Тэдний дунд байгаа эвэртэй эрэгчнийг би олж харсан.

**Редактор: Бөхөн хамгааллын талаар хийж буй ажлаа та хэзээнээс эхлэсэн бэ?**

**А.К.:** 2000 онд цэргийн албанаас чөлөөлөгдсөний дараа надад Степной БНГ-ын захирлаар ажиллаж бөхөн хамгаалах боломж олдсон. Байгаль хамгаалах идэвхтнүүдийн багийг бүрдүүлэн, бөхөнд шаадлагатай байгаа хамгаалалтыг бий болгож, орон нутгийн хүн амын дунд мэдээлэл сурталчилгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэн, Степной БНГ болон хөрш зэргэлдээх нутагт хууль бус ан хийх аливаа оролдлогыг таслан зогсоохоор ажиллаж байна.

**Редактор: Таны ажлын өдөр хэрхэн өнгөрдөг вэ?**

**А.К.:** Би өөрийгөө захиргааны ажилтан гэж боддоггүй, харин бичиг цаасныхаа ажлыг аль болох хурдан хугацаанд хамгийн сайнаар хийгээд ихэнх цагаа нөөц газрын хяналт, шалгалтын ажилд зарцуулдаг. Миний ажлын өдрүүд янз бүрийн үйл явдлаар дүүрэн байдаг. Өөрсдийн албан үүргээ гүйцэтгэхийн хажуугаар манай баг нөөц газарт зочлон ирсэн судлаачид, оюутнуудын гүйцэтгэж байгаа судалгаа, шинжилгээний ажилд тусалдаг. Бид "STS", "ZOO TV" болон Их Британий кино багийнханы бүтээсэн олон нийтэд зориулсан болон шинжлэх ухааны баримтат киног хийхэд хэд хэдэн удаа оролцсон. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн Алин Кюль



Зургийг Елена Заркова

Анатолий Клуднев ба Зоо ТВ кино багийнханы хамт.

**Редактор: Таны ажлын хамгийн сайхан зүйл нь юу вэ?**

**А.К.:** Маш сайн зохион байгуулагдсан багт байх Үнэнч шударга байдал, Дотоод сэтгэлийн ухамсар нь хоосон үг биш юм!!! Багийнхаа бүх гишүүдтэй чин сэтгэл, зүрхнээсээ хамтран ажиллахыг эрмэлзэж гэмээн бидний хүн бүр өөрсдийн үр дүнг олж авах юм! Бидний үр дүн бол ямарваа нэг зүйл маш энгийн байх эдгээр нөхцөлд бөхөнг эсэн мэнд үлдэхэд нь туслах явдал билээ.

**Редактор: Бөхөн хамгааллын хэтийн төлөвлөгөө юу вэ? Энэ зүйлийг хамгаалахад туслахын тулд эхний ээлжинд юу хийх ёстой вэ?**

**А.К.:** Одоо Халимагийн БНУ-д хууль бус агнуурыг зогсоохоор тэмцэж байна. Хэрвээ бид Улсын тусгай хороо байгуулахгүй бол Оросын бөхөнгийн популяцийн ирээдүй аюултай нөхцөлд хэвээрээ байх болно.

**Редактор: Та байгаль хамгаалах салбарт 10 гаруй жил ажиллажээ. Эдгээр жилүүдэд юу өөрчлөгдсөн бэ? Хамгааллын өнөөгийн хандлага юу вэ?**

**А.К.:** Өөрчлөлтүүд Астрахань мужид ихэвчлэн илэрч байна. Орон нутгийн хүмүүсийн хууль бус агнуур үндсэндээ зогссон. Халимагийн оршин суугчдын ан хийдэг байдал цөөрсөн боловч өнөөг хир Халимагийн бөхөн агнуурыг зогсоох талаар

тодорхой хэлж мэдэхгүй хэвээр байна. Бид 2000-2007 онд популяцийн тоог 20000 орчимд хүргэж тогтворжуулахыг хичээсэн. Халимагт улсын захиргааг татан буулгаснаар байгаль хамгаалах хүчин бүс нутгийн хяналтаа алдаж, байгаль хамгаалах үйл ажиллагаа нуран унасан. 2008 онд 9 сарын турш үндсэндээ ямар ч хамгаалалтгүй байсан. Энэ шалтгааны улмаас 2010 онд бөхөнгийн популяци 12000 бодгаль хүртлээ буурсан. Өнөөгийн байдлаар Оросын бөхөнгийн популяци 7000 бодгалиас хэтрэхгүй байна.

**Редакторын тэмдэглэл:** Степной БНГ-г хүрсэн үр дүнг үндэслэн Анатолийг шинээр байгуулагдсан “Волга-Актюбинск Интерфлюв” бүс нутгийн нөөц газрын даргаар тохоон томилсон. Бид Анатолийн шинэ ажилд амжилт хүсэж байна. Түүнтэй хамт Степной нөөц газрыг хөл дээр босгохоор эхнээс нь хамтран ажиллаж байсан түүний орлогч Владимир Калмыков Степной БНГ-ын шинэ даргаар тавигдсан. Бид түүнийг бүх талаар дэмжиж, Степной БНГ хамгийн сайн ажлын хүч байх болно гэдэгт итгэж байна.

Зургаа: Анатолий Круцев



Степной БНГ-г уус ууж буй бөхөнгүүд.

## Зарлал

### Бөхөнгийн мэдээллийн төв үүдээ нээлээ!



Бөхөн хамгаалах нийгэмлэг, Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, Нүүдэллэдэг амьтдыг хамгаалах Бонны конвенци Бөхөнгийн мэдээллийн төв албан ёсоор нээгдсэнийг баяртайгаар зарлаж байна. Энэхүү цахим хуудас нь дэлхий даяар бөхөн хамгаалалд нэгдэхэд, мөн бөхөн хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа болон ажиллах сонирхолтой олон тооны байгууллага, хувь хүмүүсийг өөр хоорондоо санаа бодол, туршлага, мэдээллээ хуваалцахад, бөхөн хамгааллын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг сайжруулахад гол тулгуур цэг байх болно.

Бөхөнгийн мэдээллийн төв рүү 4 хэлээр хандах боломжтой:

Англи: <http://www.saigaresourcecentre.com/>

Орос: <http://ru.saigaresourcecentre.com/>

Хятад: <http://cn.saigaresourcecentre.com/>

Казах: <http://kz.saigaresourcecentre.com/>

Уг сайт нь 3 үндсэн үйл ажиллагаатай. Эхнийх нь бөхөн болон түүний хамгааллын тухай танилцуулга байх болно. Уг сайтыг хэрэглэгчид өргөн хүрээнд ашигтай мэдээллээр хангахаар зохион байгуулагдсан.

Анх удаа бөхөнгийн тухай мэдэх гэж хүмүүст уг зүйлийн тухай, ЗАНЗХК-ийн харилцан ойлголцлын санамж бичгийн гол хамгааллын утга санааг ойлгуулж чадна. Мөн уг сайтад мэргэжлийн бөхөн хамгаалагч нарт хэрэгтэй мэдээллийг ЗАНЗХК-ийн харилцан ойлголцлын санамж бичгийн тайлангийн форматаар агуулсан.

Цахим хуудасны хоёрдахь үйл ажиллагаа нь мэдээллийн агуулахын үүрэг гүйцэтгэн. Та энэ хэсэг рүү хандсанаар бөхөнгийн тухай олон зураг, видео, ном зохиол, хүрээлэн буй орчны боловсролын үйл ажиллагаа зэрэг олон зүйлийг олж болно. Уг цахим хуудсанд буй эдгээр мэдээлэл нь бөхөнгийн судалгаа болон хамгааллын үйл ажиллагааг дэмжих зорилготой хэнд ч хаанаас ч хандсан нээлттэй байх болно. Тухайн улстай холбоотой олон тооны мэдээлэл одоогоор тус цахим хуудсанд тавигдаагүй болохыг бид хүлээн зөвшөөрч байна. Уг цахим хуудасыг сайжруулах зорилгоор Бөхөнгийн мэдээ уншигч бүх хүмүүст хэлэхэд бөхөнтэй холбоотой зураг, видео, хэвлэгдсэн мэдээлэл (ямар ч хэл дээр байж болно), боловсролын үйл ажиллагааны танилцуулга байгаа хэн бүхэн [saigaresourcecentre@gmail.com](mailto:saigaresourcecentre@gmail.com) хаягаар холбогдож болох бөгөөд бид уг хуудсанд таны мэдээллийг оруулах хамгийн

тохиромжтой арга замын талаар хэлэлцэх болно. Гуравдахь, хамгийн чухал хэсэг нь Судлаачдын мэдээллийн хэсэг юм. Цахим хуудасны нууц үгээр хамгаалагдсан уг хэсгийг бөхөн судлаач нарыг ашиглах боломжтойгоор зохицуулсан. Та орчуулагч, байгаль хамгаалагч, судалгаа шинжилгээ гэх мэт бөхөнтэй холбоотой ямарваа нэгэн мэргэжлээр ажилладаг бол энэ хэсэг нь өөрийн хувийн хуудсыг үүсгэн, өөрийн ажлын тухай мэдээллийг хуваалцах боломжоор хангана. Бөхөн судлаачдын хуудсыг үүсгэнээр өөрсдийн ажил, туршлагын талаар өөр өөр уулсын хоорондох харилцаа холбоог нэмэгдүүлэх, туршалаа хувалцахад туслах болно. Энэ хэсэг нь цаашид илүү их үр дүнтэй, бүтээмж сайтай төслийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд ЗАНЗХК-ийн харилцан ойлголцлын санамж бичгийн зорилгуудад чиглэсэн ажлын хэрэгжилтийг хангах болно.

Энд тайлбарлаж байснаас илүүтэйгээр хуудас руу орж илүү их зүйлийг олж үзэхийн тулд таныг цахим хуудсанд хандана гэдэгт итгэлтэй байна. Бид Бөхөнгийн мэдээллийн төвд таны оролцоог хүсэж байгаа бөгөөд ингэснээр та бид хамтдаа бөхөн хамгааллыг сонирхож буй хүмүүсийн хүчтэй сүлжээг үүсгэж чадах ба уг зүйлийг хамгийн сайнаар хамгаалж чадах болно.



Зүрлэг: Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ

## Гэгээн дурсгалд

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн эртний анд, дэмжигч Жой Ковей саяхан эмгэнэлтэйгээр өөд болсоныг мэдээлж буйд харамсаж байна. Жой 50 настай байсан бөгөөд анх байгуулагдсан цагаас эхлэн Амазоны анхны ахлах санхүүгийн ажилтнаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан.

Жой болон түүний найман настай хүү Тейлор нь энэхүү ер бусын амьтдыг хайрлан хамгаалах үйлсэд дуртай байсан ба бөхөн хамгаалах бидний ажлыг ихээхэн сонирхож байв. Бид Узбекистан дахь бидний төслийг, ялангуяа хүүхдүүдийн байгаль хамгаалах клуб, эмэгтэйчүүдийн уран хатгамал хийх салбарыг дэмжиж байсан тэдэнд гүнээ талархаж байна. Бид Тайлор болон түүний гэр бүлтэй энэхүү гунигт цаг хугацаанд үргэлж хамт байх болно.

## Талархал

Бид Бөхөн хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагааг мөнгө санхүү болон цаг хугацаагаар дэмжин ажиллаж буй бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархаж байна. Бид Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний ажилтан, сайн дурынханд тэдний дэмжлэг, зөвлөгөөний төлөө онцгойлон талархаж байна. Мөн сэтгүүлийн шинэ дугаарыг ивээн тэтгэсэн байгууллагууд болох Руфффордын жижиг тэтгэлгийн сан, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газарт талархаж байна.

**Редакторын баг.** : Хятад: А. Канг ([akang@wcs.org](mailto:akang@wcs.org)) & Фенглиан Ли ([fli@wcs.org](mailto:fli@wcs.org)) WCS China; Казахстан: Профессор А. Бекенов & док Ю.А. Грачев, Зоологийн хүрээлэн ([teriologi@mail.ru](mailto:teriologi@mail.ru)), О. Климанова, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг ([olga.klimanova@acbk.kz](mailto:olga.klimanova@acbk.kz)); Монгол: доктор Б.Лхагвасүрэн ([lkhagvazeer@gmail.com](mailto:lkhagvazeer@gmail.com)), Монголын ШУА-ийн Биологийн хүрээлэн, Б. Чимэддорж ([chimeddorj@wwf.mn](mailto:chimeddorj@wwf.mn)), ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Орос: Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв ([saiga-center@mail.ru](mailto:saiga-center@mail.ru)) & док А. Луцкекина, Экологи эволюцийн хүрээлэн ([saigak@hotmail.com](mailto:saigak@hotmail.com)); Узбекистан: Е. Быкова [Гүйцэтгэх редактор] & док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн ([esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж ([e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)) & док Давид Маллон [Шүүмжлэгч], IUCN Туруутны мэргэжлийн баг, [d.mallon@zoo.co.uk](mailto:d.mallon@zoo.co.uk); График дизайныг Виктор Григорьев, [mooglik@mail.ru](mailto:mooglik@mail.ru).

Бүх өгүүллийг бидний хэрэглэдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz) хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Материалаа [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz) хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com) хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай ([esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com), <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.